

Анхааруулга

Энэхүү хуулийн төсөл нь Улсын Их Хурал болон Засгийн газарт танилцагдаагүй бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан хувилбар юм. Энэхүү хуулийн төслийг хөрөнгийн зах зээлийн мэрэгжлийн оролцогчид, судлаачдад танилцуулж санал авах зорилгоор цахим хуудсанд байршуулав.

Хуулийн төслийн талаарх саналаа 2011 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны info@frc.mn цахим хаягаар, эсхүл тус Хорооны Үнэт цаасны газрын мэргэжилтэн С.Оюунцэцэгт /ажлын утас 261657/ бичгээр ирүүлэх боломжтой.

Төсөл 2011.02.10

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр дэд бүлэг

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь шударга, ил тод, үр ашигтай, зохицуулалт бүхий үнэт цаасны зах зээлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн эрсдлийг бууруулах болон үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааг зохицуулах, хянахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж

2.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Аудитын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах болон зохицуулалттай үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхтэй холбогдсон харилцааг энэхүү хуулиар зохицуулна.

3.2. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, арилжихтай холбогдсон нарийвчилсан харилцааг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

3.4. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон нарийвчилсан харилцааг энэ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан тусгай хуулиар зохицуулна.

3.5. Хувийн болон төрийн өмчийн тэтгэврийн сангийн хөрөнгөөр үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, тусгайлсан харилцааг тусгай хуулиар зохицуулна.

3.6. Банк, банк бус санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдээс үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, бусад тусгайлсан харилцааг тус бүрийн найрийвчлан зохицуулалт бүхий хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “үнэт цаасны зах зээл” гэж үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах арилжааг төвлөрүүлэн гүйцэтгэдэг, байнгын ажиллагаа бүхий зохицуулалттай зах зээлийг;

4.1.2. “зохицуулалттай зах зээл” гэж энэ хуульд заасны дагуу үнэт цаасны арилжаа зохион байгуулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээд, зохих нөхцөл, шаардлагыг хангасны үндсэн дээр зохион байгуулж буй үнэт цаасны зах зээл;

4.1.3. “зохицуулалтгүй зах зээл” гэж хууль тогтоомжоор хориглоогүй санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах харилцааг талууд хоорондоо шууд гэрээ байгуулах замаар үүсгэж буй хаалттай зах зээлийг;

4.1.4. “үнэт цаасны анхдагч зах зээл” гэж үнэт цаас гаргагч үнэт цаасаа нийтэд эсхүл хаалттай хүрээнд санал болгох замаар бусдад анх худалдах, үнэт цаас борлуулсны орлогыг тухайн үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн өмчлөлд шилжүүлэн авах харилцааг;

4.1.5. “үнэт цаасны хоёрдогч зах зээл” гэж аливаа үнэт цаасыг үнэт цаас гаргагчаас худалдаж авсан этгээд уг үнэт цаасыг бусдад худалдах, худалдан авахтай холбогдсон харилцааг;

4.1.6. “санхүүгийн хэрэгсэл” гэж үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, мөнгөний зах зээлд арилжаалах санхүүгийн хэрэгсэл болон зохицуулалттай зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн санхүүгийн бусад хэрэгслийг;

4.1.7. “үүсмэл санхүүгийн хэрэгсэл” гэж зохицуулалттай зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, опцион болон фьючерсийн гэрээг;

4.1.8. “үнэт цаас” гэж энэ хуулийн 5 дугаар зүйлд тодорхойлсон санхүүгийн хэрэгслийг;

4.1.9. “өрийн бичиг” гэж өрийн бичиг гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц өрийн бичгийн үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хөрөнгө, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр өрийн бичгийг худалдан авсан этгээдэд эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг;

4.1.10. “опционы гэрээ” гэж худалдан авагч тал нь гэрээний зүйл болох тодорхой тоо, хэмжээ бүхий хөрөнгийг тогтоосон хугацаанд, тохиролцсон үнээр эргүүлэн худалдан авахыг худалдагч талаас шаардах, эсхүл опцион гэрээний зүйлийг түүнд худалдахыг шаардах эрхийг худалдан авсан талд үүсгэх боловч үүргийг бий болгодоггүй, харин худалдагч талд худалдан авагчийн шаардлагыг биелүүлэх үүргийг үүсгэдэг санхүүгийн үүсмэл хэрэгслийг;

4.1.11. “фьючерсийн гэрээ” гэж худалдан авагч талд тодорхой төрлийн, тодорхой тоо, хэмжээ бүхий хөрөнгийг тогтоосон хугацааны дараа, урьдчилан тохиролцсон үнээр худалдан авах үүргийг бий болгох, худалдагч талд гэрээний зүйлийг нийлүүлэх үүргийг харилцан бий болгох нөхцөл бүхий санхүүгийн үүсмэл хэрэгслийг ойлгоно. Гэрээнд өөрөөр заагаагүй бол фьючерсийн гэрээний хэрэгжилтийг хангах үед гэрээ байгуулах үеийн д болон гэрээг хэрэгжүүлэх үеийн үнийн зөрүүг харгалзахгүй;

4.1.12. “хадгаламжийн бичиг” гэж үнэт цаас гаргагчаас өөрийн гаргасан суурь үнэт цаас /хувьцаа/-аа үнэт цаасны хадгаламжийн эсхүл кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад тогтоосон дүрэм, журмын дагуу хадгалуулж, хадгалалтад авсан үнэт цаасны хадгаламжийн эсхүл кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага нь тухайн суурь үнэт цаасны анхны бүртгэл бүхий зах зээлээс бусад зах зээлд арилжаалах зорилгоор гаргах үнэт цаасыг;

4.1.13. “суурь үнэт цаас” гэж хадгаламжийн бичгийн суурилан гаргасан үнэт цаас /хувьцаа/-ыг;

4.1.14. “үнэт цаасны танилцуулга” гэж нийтэд /нээлттэй хүрээнд/ эсхүл тодорхой этгээдэд /хаалттай хүрээнд/ санал болгох замаар үнэт цаасыг бусдад худалдах зорилгоор худалдан авагчид зориулан үнэт цаасны хууль тогтоомжид заасан журмын дагуу үнэт цаас гаргагчийн бэлтгэн баталгаажуулсан танилцуулга, холбогдох баримтын бүрдлийг;

4.1.15. “үнэт цаасны зах зээлийн оролцогч” гэж зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж буй этгээд, мэргэжилтэн, үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагч буюу харилцагч, үнэт цаас эзэмшигчийг;

4.1.16. “зохицуулалттай этгээд” гэж энэ хуулийн 26.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, мэргэжилтэнг;

4.1.17. “харилцагч” гэж зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлх эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулах замаар мэргэжлийн үйлчилгээ авч байгаа иргэн, хуулийн этгээдийг;

4.1.18. “мэргэжлийн хөрөнгө оруулагч” гэж үнэт цаасны зах зээлд дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд болон Хорооноос мэргэжлийн хөрөнгө оруулагч гэж тодорхойсон хуулийн этгээдийг;

4.1.19. “үнэт цаас гаргагч” гэж энэ хуульд заасны дагуу үнэт цаасны зах зээлд худалдах үнэт цаасаа Хороонд бүртгүүлсэн буюу бүртгүүлэх хүсэлт гаргаж буй хуулийн этгээдийг;

4.1.20. “нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл” гэж энэ хуульд заасан журмын дагуу Хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн санхүүгийн хэрэгслийн бүртгэлийг;

4.1.21. “үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл” гэж эрх бүхий үнэт цаас бүртгэгчээс тогтоосон журмын дагуу хөтөлөх тухайн санхүүгийн хэрэгслийг өмчлөгч этгээдийн өмчлөх эрхийг баталгаажуулах нэгдсэн бүртгэлийг;

4.1.22. “хөрөнгийн биржийн бүртгэл” гэж хөрөнгийн биржээс тухайн хөрөнгийн биржийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн санхүүгийн хэрэгслийн бүртгэлийг;

4.1.23. “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж компанийн нийт гаргасан саналын эрхтэй хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа, эсхүл гэрээний үндсэн дээр саналын эрхийг хэрэгжүүлж байгаа хувьцаа эзэмшигчийг;

4.1.24. “холбогдох этгээд” гэж дор дурдсан этгээдийг ойлгоно:

4.1.24.1. хувь хүний хувьд тухайн хүний эхнэр, нөхөр, хүү, охин, өргөмөл хүү, өргөмөл охин буюу дагавар хүү, дагавар охин, хүргэн, бэр, ач, зээ, худ, эцэг, эх, хойт эцэг, эх, ах, эгч, дүү, эцэг нэгтэй буюу эх нэгтэй ах, эгч, дүүг;

4.1.24.2. тухайн хүн захирлаар нь ажилладаг компанийг;

4.1.24.3. энэ заалтын 4.1.24.1-д заасан этгээдийн дангаар эсхүл хамтдаа саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг компанийг;

4.1.24.4. тухайн этгээд ажил олгогч бол түүний ажилтныг;

4.1.24.5. компани бол түүний толгой, хараат, охин, зэргэлдээ компанийг;

4.1.25. “хуулийн этгээдийн нэгдэл” гэж зохицуулалттай этгээдтэй дараах холбоотой хуулийн этгээдүүдийг:

4.1.25.1. зохицуулалттай этгээдийн толгой компани, нөхөрлөл, бусад хуулийн этгээд;

4.1.25.2. зохицуулалттай этгээдийн хараат, охин, зэргэлдээ компани, нөхөрлөл, бусад хуулийн этгээд;

4.1.25.3. зохицуулалттай этгээдийн хараат, охин компанийн толгой компани, бусад хуулийн этгээд;

4.1.25.4. зохицуулалттай этгээдийн 4.1.25.1-4.1.25.3-д заасан хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшиж буй этгээд.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ҮНЭТ ЦААС ГАРГАХ, АРИЛЖИХ

Хоёрдугаар дэд бүлэг

Үнэт цаас гаргах

5 дугаар зүйл. Үнэт цаас

5.1. Энэ хуулиар зохицуулалтад хамрагдах үнэт цаасанд дор дурдсан санхүүгийн хэрэгсэл хамаарна:

5.1.1. арилжаа эрхлэх эрх бүхий байгууллагад бүртгэл бүхий хувьцаат компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлж байгаа энгийн болон давуу эрхийн хувьцаа /цаашид “хувьцаа” гэх/;

5.1.2. компанийн өрийн бичиг;

5.1.3. Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн бичиг;

5.1.4. Төв банкнаас гаргасан нэгээс дээш жилийн хугацаатай өрийн бичиг;

5.1.5. хөрөнгө оруулалтын компанийн хувьцаа, хамтын сангийн нэгж эрх;

5.1.6. хадгаламжийн бичиг;

5.1.7. үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагчдад санал болгож байгаа тодорхой тооны хувьцаа болон өрийн хэрэгслийг тодорхой хугацааны дотор тохиролцсон үнээр захиалах эрх буюу варрант;

5.1.8. энэ хуулийн хүрээнд Хорооноос үнэт цаас гэж тооцсон бусад санхүүгийн хэрэгслийг.

5.2. Дор дурдсан санхүүгийн хэрэгсэл энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй:

5.2.1. хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гаргасан хувьцаа;

5.2.2. зохицуулалттай зах зээлд арилжахыг зөвшөөрөөгүй санхүүгийн үүсмэл хэрэгсэл;

5.2.3. шилжүүлгийн болон энгийн вексель;

5.2.4. арилжааны банкнаас гаргасан хадгаламжийн сертификат;

5.2.5. Банкны тухай хуулийн 15.2-т заасны дагуу арилжааны банкнаас мөнгөний зах зээлд арилжаалахаар гаргаж буй нэг жил хүртэлх хугацаатай бусад санхүүгийн хэрэгсэл.

5.3. Таваарт суурилсан санхүүгийн үүсмэл хэрэгсэл гаргах, арилжихтай холбоотой харилцааг Санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн биржийн тусгайлсан журмаар зохицуулна.

6 дугаар зүйл. Үнэт цаас гаргах

6.1. Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихаар, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргаж болно.

6.2. Үнэт цаасыг Монгол Улсын нутаг дэвсгэрт, эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт арилжаалахаар гаргаж болно.

6.3. Үнэт цаас гаргах шийдвэрийг тухайн хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллага гаргана. Хууль эхсүл тухайн хуулийн этгээдийн дүрмээр эрх олгосон бол тухайн хуулийн этгээдийн эрх барих дараагийн шатны байгууллага үнэт цаас гаргах шийдвэрийг гаргана.

6.4. Гаргаж байгаа үнэт цаасыг Хороонд бүртгүүлсэн эсхүл уг үнэт цаасыг бусдад худалдсанаас хойш тухайн үнэт цаасыг гаргах тухай шийдвэрийг өөрчлөхийг хориглоно.

6.5. Үнэт цаасны зохицуулалттай зах зээлд худалдах үнэт цаасыг гагцхүү нэрийн үнэт цаасны хэлбэрээр гаргана.

6.6. Үнэт цаасны зохицуулалттай зах зээлд анхлан үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа этгээд өмнө нь мэдүүлгийн эсхүл зөвшөөрлийн үнэт цаас гаргасан бол тэдгээр үнэт цаасыг зохих журмын дагуу нэрийн үнэт цаасанд хөрвүүлнэ.

7 дугаар зүйл. Үнэт цаас гаргагч

7.1. Ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд Компанийн тухай хууль болон энэ хуульд заасны дагуу үнэт цаас гаргаж болно.

7.2. Үнэт цаасны зохицуулалттай зах зээлд хувьцааг гагцхүү хуулийн этгээдийн улсын бүртгэлд хувьцаат компани гэж бүртгэгдсэн бөгөөд хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээд гарган худалдаж болно.

7.3. Засгийн газар Улсын Их Хурлын зөвшөөрлөөр, аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зөвшөөрлөөр нийтэд санал болгон үнэт цаас гаргаж болно.

8 дугаар зүйл. Нийтэд санал болгон арилжихаар үнэт цаас гаргах ажиллагааны дараалал

8.1. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үнэт цаасыг нийтэд санал болгон арилжихаар үнэт цаасны анхдагч зах зээлд дор дурдсан дарааллын дагуу гаргана:

8.1.1. үнэт цаас гаргагч нь өөрийн эрх бүхий байгууллагаараа үнэт цаас гаргах тухай шийдвэр гаргуулах;

8.1.2. үнэт цаас гаргах бэлтгэлийг хангах, үнэт цаасны танилцуулга, холбогдох баримтыг боловсруулах;

8.1.3. үнэт цаас гаргагч өөрийн эрх бүхий байгууллагаараа энэ хуулийн 8.1.2-т заасан баримт, үнэт цаасны танилцуулгын төслийг хэлэлцүүлэн батлуулах;

8.1.4. үнэт цаасаа хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэх эсхүл хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэхэд татгалзах зүйлгүй болох тухай харъяалах үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаасаа дүгнэлт гаргуулах;

8.1.5. үнэт цаасыг Хороонд хөтлөх нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх, уг үнэт цаасыг нийтэд санал болгох зөвшөөрөл авах;

8.1.6. үнэт цаасыг үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлд бүртгүүлэх;

8.1.7. үнэт цаасыг Хороонд хөтлөх нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргахаас өмнө тухайн үнэт цаасыг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлээгүй бол харъяалах хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэх, үнэт цаасыг нийтэд санал болгох;

8.1.8. Хорооноос өгсөн зөвшөөрлийн дагуу үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдах;

8.1.9. үнэт цаас гаргасан тайлан, тооцоог зохих журмын дагуу Хороо, хөрөнгийн биржид хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх.

8.2. Засгийн газар, аймаг, нийслэл өрийн бичиг гаргах шийдвэр гаргахтай холбоотой журмыг Засгийн газар, Монголбанк үнэт цаас гаргах шийдвэр гаргахтай холбоотой журмыг Монголбанкны Ерөнхийлөгч тус тус батална.

8.3. Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн дагуу нөөц нь бүрэн тогтоогдоогүй ашигт малтмалын ордод хайгуулын ажил хийх, олборлолт явуулах зорилгоор нийтэд үнэт цаас санал болгон хөрөнгө оруулалт татахыг хориглоно.

8.4. Нийтэд санал болгон худалдахаар үнэт цаасыг гаргах ажиллагааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, үнэт цаасны танилцуулгыг боловсруулах аргачлалыг Хороо болон хөрөнгийн биржээс батлан гаргаж болно.

9 дүгээр зүйл. Үнэт цаасыг бүртгэх

9.1. Хуульд өөрөөр заагаагүй бол нийтэд санал болгох үнэт цаасыг гагцхүү Хороо бүртгэн нийтэд санал болгох зөвшөөрлийг олгох бөгөөд уг үнэт цаасны нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгыг Хороо батламжлана.

9.2. Үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, үнэт цаасны танилцуулгыг батламжлах нийтлэг журмыг Хороо тогтооно.

9.3. Засгийн газар, Монголбанк, аймаг, нийслэлийн өрийн бичгийг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд хялбаршуулсан горимын дагуу бүртгэж болох бөгөөд журмыг Хороо тогтооно.

9.4. Хуульд өөрөөр заагаагүй бол өмнө нь нийтэд санал болгох замаар үнэт цаас гаргасан хуулийн этгээдийн уг үнэт цаасыг нэмж гаргахдаа хаалттай хүрээнд худалдахаар шийдвэрлэсэн бол тухайн нэмж гаргаж буй үнэт цаасыг энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу Хороонд бүртгүүлнэ.

9.5. Хуульд өөрөөр заагаагүй бол өмнө нь нийтэд санал болгох замаар үнэт цаас гаргасан хуулийн этгээд өөр төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар шинээр эсхүл нэмж гаргаж байгаа бол уг шинээр эсхүл нэмж хаалттай хүрээнд худалдахаар гаргаж үнэт цаасыг Хороонд бүртгүүлнэ.

9.6. Хорооноос үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэснийг Хорооноос өгч буй аливаа баталгаа гэж үзэхгүй бөгөөд үнэт цаасыг худалдан авсны улмаас үүсэх аливаа хохирлыг Хороо хариуцахгүй.

9.7. Үнэт цаас бүртгүүлэх хүсэлтэд дурдсан мэдээллийн үнэн зөв эсэх болон түүнтэй холбоотой бусдад учирсан хохирлыг үнэт цаас гаргагч хариуцна.

9.8. Хороо нь энэ хуулийн 9.3-т зааснаас бусад үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор бүртгэх эсэх шийдвэрийг гаргана. Хугацааг зохих шаардлагыг хангасан, бүрдэл бүрэн хүсэлтийг хүлээн авсан өдрөөс тооцох ба нэмэлт баримт шаардлагатай тохиолдолд Хороо хүсэлт шийдвэрлэх хугацааг ажлын 30 хүртэл хоногоор тухай бүр сунгаж болно.

9.9. Үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд дор дурдсан баримтыг хавсаргана:

9.9.1. үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх өргөдөл;

9.9.2. үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт;

9.9.3. тухайн үнэт цаасыг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэсэн тухай, эсхүл бүртгэхэд татгалзах зүйлгүй тухай харъяалах хөрөнгийн биржээс ирүүлсэн тодорхойлолт;

9.9.4. зохицуулалт үйлчилгээний хөлсийг төлсөн тухай баримт;

9.9.5. үнэт цаас гаргагчаас шаардлагатай гэж үзсэн болон холбогдох нарийвчилсан журмын дагуу бүрдүүлж ирүүлэхээр заасан бусад баримт.

9.10. Хороо хүсэлтийг хүлээж аваад шаардлагатай гэж үзвэл нарийн мэргэжлийн асуудлаар хөндлөнгийн шинжээчийг томилон ажиллуулж болно. Энэ тохиолдолд шинжээчин зардлыг хүсэлт гаргагч хариуцана.

9.11. Хороо хууль тогтоомжоор тогтоосон мэдээлийг зохих журмын дагуу бүрэн хамруулсан бөгөөд ирүүлсэн үнэт цаасны танилцуулгад тулгуурлан нийтэд

санал болгох үнэт цаасыг танилцуулах боломжтой гэж үзвэл үнэт цаасны танилцуулгыг баталгаажуулж тухайн үнэт цаасыг бүртгэн, нийтэд санал болгох зөвшөөрлийг олгоно.

9.12. Хороо дор дурдсан тохиолдолд үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхээс татгалзана:

9.12.1. үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг зохих журмын дагуу гаргаагүй;

9.12.2. үнэт цаас гаргагч нь эсхүл түүний гаргасан хүсэлт болон түүнд хавсарган ирүүлсэн баримт нь тогтоосон шаардлагыг хангаагүй;

9.12.3. шаардлагатай мэдээллийг хүсэлтэд тусгаагүй;

9.12.4. шаардлагатай мэдээллийг дутуу тусгасан;

9.12.5. холбогдох мэдээлэл нь хоорондоо зөрчилтэй;

9.12.6. худал мэдээлэл тусгасан;

9.12.7. шаардлагатай нэмэлт мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлээгүй;

9.12.8. тухайн үнэт цаасыг бүртгэх нь нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж Хороо үзсэн.

9.13. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхээс татгалзсан болон бүртгэлд хамрагдаагүй үнэт цаасны танилцуулгын олон нийтэд танилцуулах, аливаа зар сурталчилгаа явуулахыг хориглоно.

9.14. Үнэт цаас гаргагч гаргаж буй үнэт цаасаа нийтэд санал болгохыг зөвшөөрсөн бүртгэлд бүртгүүлэхээр Хороонд хүсэлт гаргахын хамт хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг нэгэн зэрэг гаргаж болно. Хороо шийдвэр гаргахаас өмнө хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэгдсэн нь тухайн үнэт цаасыг нийтэд санал болгох, эсхүл нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх үндэслэл болохгүй.

10 дугаар зүйл. Үнэт цаасны танилцуулга

10.1. Үнэт цаасны танилцуулга нь Хороо батламжилснаас хойш 6 сарын хугацаанд хүчинтэй байна. Энэ хугацаанд тухайн үнэт цаасны танилцуулгад үндэслэн үнэт цаасыг нийтэд санал болгох ба танилцуулга хүчинтэй байх хугацаа дууссан өдрөөс хойш уг үнэт цаасыг нийтэд санал болгохыг хориглоно.

10.2. Энэ хуулийн 10.1-д заасан хугацаа дуусгавар болсон эсхүл уг хугацаа дуусгавар болсноос хойш 6 сарын хугацаанд үнэт цаасны танилцуулгыг Хороонд хүсэлт гаргах замаар шинэчлэн батламжлуулаагүй бол тухайн үнэт цаасны бүртгэлийг Хороо хүчингүй болгоно.

10.3. Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны танилцуулгын агуулгад тавигдах шаардлага, хэлбэр болон танилцуулгыг бэлтгэх нарийвчилсан журмыг Хороо тогтооно.

10.4. Үнэт цаасны танилцуулга нь үнэт цаас гаргагчийн тухай, түүний хувьцаа эзэмшигчид, удирдлага, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтан, үнэт цаас гаргагчийн хөрөнгө, өр төлбөр, санхүүгийн байдал, өнөөгийн болон ирээдүйн боломж, эрсдэл, гаргаж буй үнэт цаас, тухайн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрх, үнэт цаасыг худалдах журам болон хөндлөнгийн үнэлэлт, дүгнэлт зэрэг хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг бүрэн агуулсан байна.

10.5. Үнэт цаасны танилцуулгад дор дурдсан мэдээллийг заавал тусгана:

10.5.1. Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байх, шуудангийн болон холбоо барих хаяг; эрхэлж буй үйл ажиллагаа, хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх тухай;

10.5.2. үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, хүчинтэй хугацаа;

10.5.3. үнэт цаас гаргагчийн гаргасан саналын эрх бүхий нийт хувьцааны таваас дээш хувийг өмчлөгч хувьцаа эзэмшигчдийн овог, нэр, регистрийн болон иргэний үнэмлэхийн дугаар, тэдгээрийн дангаар болон нэгдмэл сонирхолтойгоор эзэмшиж буй хувьцааны тоо, хувь хэмжээ;

10.5.4. сүүлийн гурван жилийн байдлаарх үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт, тэдгээрийн өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээ;

10.5.5. үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө /дүрмийн сан/-ийн хэмжээ, өмнө гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, биет болон биет бус хөрөнгийн тухай;

10.5.6. аудитын байгууллага хянаж баталгаажуулсан сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлан, өр, зээлийн талаарх дүгнэлт;

10.5.7. үнэт цаас гаргагч бусдын өмнө хүлээсэн түүний дүрмийн сангийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээ, хэлцлийн тухай болон дүрмийн сангийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийн үүргийн гүйцэтгэлийн тухай;

10.5.8. үнэт цаас гаргагчийн холбоотой болон холбогдох этгээдийн тухай;

10.5.9. нийтэд санал болгож буй үнэт цаасны тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ болон тэдгээрийг нийтэд санал болгох болон худалдах нөхцөл, журам, ногдол ашиг /өрийн бичгийн хувьд хугацаа, хүү/ төлөх журмын тухай;

10.5.10. нийтэд санал болгож буй үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг;

10.5.11. нийтэд санал болгон худалдах үнэт цааснаас олох хөрөнгө оруулалтыг ашиглах төлөвлөгөө;

10.5.12. хувьцаанд хөрвөх үнэт цаас бол тухайн үнэт цаасыг хувьцаанд хөрвүүлэх журмын тухай;

10.5.13. үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны болон тухайн үнэт цаасны үнийн эрсдлийн тухай;

10.5.14. тухайн үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд хамтран ажиллаж буй зохицуулалттай этгээд болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй этгээдийн тухай, тэдгээртэй байгуулсан гэрээ, харилцан эдлэх эрх, үүрэг, хүлээх хариуцлагын тухай;

10.5.15. өрийн хэрэгслийн тухайд эргэн төлөх баталгаа, барьцаа хөрөнгийн тухай;

10.5.16. бусад.

10.6. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад туссан мэдээлэл нь хууль зүйн хувь үнэн зөв эсэхийг хөндлөнгийн хуульчийн, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг хөндлөнгийн аудитын байгууллагаар тус тус хянуулан баталгаажуулна.

10.7. Нийтэд санал болгох үнэт цаасыг худалдах үнийг тодорхойлох аргачлал, журам, үнэт цаас гаргагчийн аудитын байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн жилийн тайлан, Хороонд тухайн үнэт цаасыг бүртгүүлэхээр хүсэлт гаргахын өмнөх санхүүгийн улирал болон сарын санхүүгийн тайлан, хуульчийн дүгнэлт нь тухайн үнэт цаасны танилцуулгын салшгүй хэсэг байна.

10.8. Үнэт цаасны танилцуулгад туссан мэдээлэлд хөндлөнгийн шинжээч, мэргэжилтний үнэлэлт, дүгнэлт багтсан бол уг баримтын талаар дор дордсан мэдээлэл, тодорхойлолтыг хавсаргасан байна:

10.8.1. тухайн дүгнэлтийг гаргах эрх бүхий болохыг нотлох баримт;

10.8.2. тухайн дүгнэлтийг гүйцэтгэсэн шинжээчийн нэр, хаяг, туршлага;

10.8.3. тухайн дүгнэлтийг аливаа сонирхлын зөрчилгүйгээр, зохих журмын дагуу гүйцэтгэсэн тухай шинжээчээс өгсөн батламж;

10.8.4. тухайн дүгнэлтийг үнэт цаасны танилцуулгын хамт нийтийн хүртээл болгоход татгалзах зүйлгүй болох тухай зөвшөөрөл.

10.9. Шинжээчийн дүгнэлт нь дор дурдсан мэдээллийг агуулна:

10.9.1. шинжээчийн адаг, эцэг /эх/-ийн нэр, нэр, шинжилгээ хийх эрх бүхий болохыг нотлох мэдээлэл;

10.9.2. шинжилгээг захиалсан этгээдийн талаарх мэдээлэл;

10.9.3. шинжилгээ хийсэн хугацаа, давтамж, огноо;

10.9.4. шинжилгээг захиалагчийн даалгавар;

10.9.5. шинжилгээнд ашигласан аргачлал, шинжилгээний хамарсан хүрээ, танилцсан баримт бичиг, хамрагдаагүй асуудлууд;

10.9.6. шинжээчийн дүгнэлтийн агуулга;

10.9.7. шинжилгээг зохих журмын дагуу гүйцэтгэсэн болон сонирхолын зөрчилгүй болох тухай шинжээчийн өчиг.

10.9.8. шинжээчийн гарын үсэг, тамга, тэмдэг;

10.9.9. Хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон бусад зүйл.

10.10. Энэ хуулийн 10.4-10.8-д зааснаас бусад танилцуулгад тусгавал зохих нэмэлт мэдээллийг Хороо тогтооно.

10.11. Хороонд ирүүлэх хүсэлт, үнэт цаасны танилцуулга болон бусад хуулбар баримтад үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан, дүгнэлт гаргасан хуульч болон санхүүгийн шалгалт хийсэн хөндлөгийн аудитор болон бусад шаардлагатай хөндлөнгийн шинжээчид гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

10.12. Үнэт цаас гаргагч нь Хорооноос батламжилсан үнэт цаасны танилцуулгад Хорооны зөвшөөрөлгүйгээр аливаа өөрчлөлт оруулахыг хориглоно.

10.13. Сонирхогч этгээд нийтэд санал болгож буй аливаа үнэт цаасны танилцуулга нь Хорооноос батламжилсан хувь мөн эсэхийг тогтоохоор Хороонд хүсэлт гаргаж болно.

10.14. Дараахь тохиолдолд үнэт цаасны танилцуулга бэлтгэхийг шаардахгүй байж болно:

10.14.1. Засгийн газрын өрийн бичиг, Монголбанкны үнэт цаасыг гаргахад;

10.14.2. бүхэлд нь Засгийн газар баталгаа гаргасан үнэт цаас гаргахад;

10.14.3. гаргасан хувьцааг нэгтгэх, эсхүл хуваахад;

10.14.4. өмнө нийтэд танилцуулсан үнэт цаасны танилцуулгын дагуу хувьцаанд хөрвөх өрийн бичгийг хувьцаанд хөрвүүлэхэд;

10.14.5. гаргаж буй үнэт цаасыг бүх хувьцаа эзэмшигчид үнэ төлбөргүйгээр эзэмшүүлж тохиолдолд;

10.14.6. хууль тогтоомжоор тогтоосон бусад нөхцөл.

10.15. Энэ хуулийн 10.14-д заасан үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэх тусгайлсан журмыг Хороо тогтооно.

11 дүгээр зүйл. Үнэт цаасыг нийтэд санал болгох

11.1 Үнэт цаасыг нийтэд санал болгох гэж үнэт цаас гаргагч дангаар, эсхүл эрх бүхий зохицуулалттай этгээдийн тусламжтайгаар гаргаж буй үнэт цаасаа үнэт

цаасны анхдагч зах зээлд бусдад худалдахаар дараах этгээдэд таниулах, сурталчлах ажиллагааг ойлгоно:

11.1.1. тавь буюу түүнээс дээш тооны тодорхой худалдан авагч буюу хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгох;

11.1.2. нийтэд нээлттэй санал болгох.

11.2. Үнэт цаасыг бусдад танилцуулахдаа гагцхүү гагцхүү Хороогоор батламжлуулсан үнэт цаасны танилцуулгад тодорхойлсон хүрээнд санал болгоно.

11.3. Үнэт цаас гаргагч үнэт цаасаа нийтэд санал болгох явцдаа тухайн үнэт цаасны танилцуулгыг сонирхсон аливаа этгээд үнэ төлбөргүй авах боломжийг бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

11.4. Үнэт цаас гаргагчаас нэмэлт мэдээлэл авах шаардлага үүссэн, эсхүл үнэт цаас гаргагч үнэт цаасыг бүртгэх явцад бусдыг төөрөгдүүлсэн, дутуу, худал мэдээлэл өгсөн, эсхүл тийм мэдээлэлд үндэслэн үнэт цаасыг нийтэд танилцуулсан, худал амлалт өгсөн болох нь тогтоогдсон тохиолдолд зөрчлийн хэр хэмжээнээс хамаарч Хороо тухайн үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагааг түдгэлзүүлэх, эсхүл бүртгэлийг хүчингүй болгож болно.

11.5. Үнэт цаас гаргагчийн буруутай үйл ажиллагааны улмаас энэ хуулийн 11.4-д заасны дагуу нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг хүчингүй болгосонтой холбоотой үүсэх зардал, бусдад учирсан хохирлыг үнэт цаас гаргагч хариуцна.

11.6. Үнэт цаас гаргах, нийтэд санал болгох ажиллагаанд оролцсон аудитор, үнэлгээчин, хуульч болон холбогдох хөндлөнгийн шинжээчид болон хөрөнгийн бирж, үнэт цаасны бүртгэл, тооцооны, төлбөрийн болон хадгаламжийн байгууллага нь энэ хуулийн 11.4-д заасан зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдсэн, эсхүл мэдээлэл авсан даруй зохих журмын дагуу Хороо болон эрх бүхий төрийн байгууллагад мэдээлэл өгөх үүрэгтэй.

11.7. Энэ хуулийн 11.4-д заасан зөрчлийн улмаас бусдад учирсан хохирлыг үнэт цаас гаргагч барагдуулсан нь уг зөрчил гаргахад оролцсон андеррайтер аудитор, үнэлгээчин, хуульч болон холбогдох хөндлөнгийн шинжээчидийг тус бүрийн эд хөрөнгийн болон захиргааны, эрүүгийн зохих хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

11.8. Энэ хуулийн 11.5-11.7-д заасан хохирлыг шүүхийн журмаар нэхэмжилнэ.

11.9. Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн бүртгэлд бүртгүүлээгүй болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааг нийтэд санал болгохыг хориглоно.

12 дугаар зүйл. Үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдах, тайлагнах

12.1. Үнэт цаасны анхдагч зах зээлд зөвхөн нийтэд санал болгохыг зөвшөөрсөн Хорооны бүртгэл болон тухайн хөрөнгийн биржийн бүртгэлд нэгэн зэрэг бүртгэгдсэн үнэт цаасыг худалдана.

12.2. Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг худалдах зөвшөөрлийг Хороо олгох бөгөөд уг шийдвэрийг харъяалах хөрөнгийн биржээс тухайн үнэт цаасыг өөрийн биржийн бүртгэлд бүртгэсэн тухай болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай тодорхойлолтын хамт ирүүлсэн хүсэлтэд үндэслэн гаргана.

12.3. Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг төлбөргүйгээр, зээлээр худалдахыг хориглоно.

12.4. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдаж дууссанаас хойш ажлын гурван хоногийн дотор анхдагч зах зээлийн гүйлгээний тайланг Хороонд ирүүлнэ. Тайланд тусгах мэдээллийг Хороо тогтооно.

12.5. Үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдсан тухай тайланд тухайн гүйлгээ нь зохих журмын дагуу явагдсан тухай арилжааг зохион байгуулсан эрх бүхий байгууллагын дүгнэлтийг хавсаргасан байна.

12.6. Үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдсан тухай тайланг Хороо ажлын 10 хоногт хянах ба зөрчил гараагүй, эсхүл анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж үзсэн тохиолдолд хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх болон үнэт цаас худалдсаны орлогыг үнэт цаас гаргагч захиран зарцуулах эрхийг нээх зөвшөөрлийг олгоно.

12.7. Хороо дор дурдсан тохиолдолд анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж үзнэ:

12.7.1. үнэт цаасыг нэрлэсэн үнээр гаргаж буй тохиолдолд нийтэд санал болгон худалдахаар тооцсон бүх хувьцаа борлогдсон буюу үнэт цаас худалдан авсан төлбөр үнэт цаас гаргагчийн холбогдох дансанд бүрэн төвлөрсөн;

12.7.2. үнэт цаасыг нэрлэсэн үнээс өөр үнээр худалдсан тохиолдолд нийтэд санал болгосон танилцуулгад дурдсан ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг бүрэн бүрдүүлж чадсан;

12.7.3. андеррайтер оролцож буй тохиолдолд андеррайтер зохих төлбөрийг бүрэн хийсэн буюу энэ хуулийн 12.7.1, 12.7.2-т заасан нөхцлийг бүрдүүлсэн.

12.8. Хорооноос үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон гэж үзсэн шийдвэрийг нийтэд мэдээлэх ба уг шийдвэр гарсан өдрөөс хойш гурван сарын хугацаанд уг шийдвэрийн талаар гомдол гаргаж болно.

12.9. Энэ хуулийн 12.6-д заасан Хорооны шийдвэр гарах хүртэл үнэт цаас гаргагч үнэт цаас худалдсаны орлогыг өмчлөх, захиран зарцуулах эрхгүй байна.

12.10. Үнэт цаасыг анхдагч зах зээлээс худалдан авах сонирхлыг баталгаажуулах, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай явуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор санал болгож буй үнэт цаасыг худалдан авах санал ирүүлсэн хөрөнгө оруулагчид захиалж буй үнэт цаасаа худалдан авахад шаардлагатай хөрөнгийг үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага дахь тусгай дансанд урьдчилан байршуулах буюу төлбөрийн чадварын баталгааг ирүүлэх нөхцлийг хөрөнгө оруулагчдад тавьж болно.

12.11. Энэ хуулийн 12.10-д заасан нөхцлийн дагуу урьдчилан байршуулсан хөрөнгийг хөрөнгө байршуулсан этгээдээс бусад аливаа этгээд өмчлөх, захиран зарцуулах эрхгүй байна.

12.12. Энэ хуулийн 12.10 дахь заалт тухайн үнэт цаасыг нийтэд санал болгоход үйлчилгээ үзүүлж буй андеррайтерт нэг адил хамаарна.

12.13. Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг танилцуулгад заасан зориулалтаар зарцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Хороо, эсхүл хөрөнгийн биржээс үнэт цаас худалдсаны орлогыг тодорхой хуваарийн дагуу захиран зарцуулах хязгаарлалт тогтоож болно.

12.14. Хороо нийтэд санал болгохыг зөвшөөрч бүртгэснээс хойш жилийн хугацаанд тухайн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдаагүй тохиолдолд тухайн үнэт цаасны бүртгэлийг хүчингүй болгоно.

13 дугаар зүйл. Хадгаламжийн бичиг

13.1. Хадгаламжийн бичгийг гагцхүү аль нэг зохицуулалттай зах зээлд үнэт цаасаа арилжих зөвшөөрөл бүхий үнэт цаас гаргагчийн үнэт цаасанд тулгуурлан гаргаж болно.

13.2. Хадгаламжийн бичиг эзэмшигчийн эдлэх эрх, хүлээх үүрэг нь тухайн хадгаламжийн бичгийн суурь үнэт цаасыг өмчлөгч бусад этгээдийн нэг адил байна.

13.3. Суурь үнэт цаасаас олох ногдол ашиг, урамшуулал зэрэг аливаа үр ашгийг хадгаламжийн бичиг эзэмшигч өмчилнө.

13.4. Энэ хуулийн 13.3 дахь заалтад хадгаламжийн бичиг гаргах ажиллагаанд мэргэжлийн ажил, үйлчилгээ үзүүлж буй хадгаламжийн эсхүл кастодианы байгууллагын үйлчилгээний төлбөр, шимтгэл хамаарахгүй.

13.5. Хадгаламжийн бичиг гаргахаад хадгаламжид байршуулах үнэт цаас нь гагцхүү тухайн суурь үнэт цаас гаргагчийн өмчлөлд байна.

13.6. Хадгаламжийн бичиг нь дор дурдсан төрөлтэй байна:

13.6.1. Монгол Улсын хадгаламжийн бичиг;

13.6.2. Гадаад улсын хадгаламжийн бичиг.

14 дүгээр зүйл. Монгол Улсын хадгаламжийн бичиг

14.1. Монгол Улсын хадгаламжийн бичиг гэж гадаад улсын хөрөнгийн биржийн бүртгэлд хамрагдсан суурь үнэт цаасыг эрх бүхий үнэт цаасны хадгаламжийн, эсхүл кастодийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагад хадгалуулж, уг үнэт цаасанд тулгуурлан Монгол Улсын үнэт цаасны зохицуулалттай зах зээлд арилжаалах зорилгоор гаргасан хадгаламжийн бичгийг ойлгоно.

14.2. Монгол Улсад хадгаламжийн бичиг гаргаж болох гадаад улсын үнэт цаасны төрөл, тухайн суурь үнэт цаасны бүртгэл бүхий харъяалах үнэт цаасны зах зээл, улсын жагсаалтыг хөрөнгийн биржийн саналыг харгалзан Хороо тогтооно.

àè-àèéí àààóó òñí ñàìàèùí àçíà òàìèèóóòèàð òàèààððè òààààèàìæèéí
ààéàóóèèààùí ççðýã;

14.6.12. эй дороеу, Өгдмгмн гадмгнги æодлааð ÿäýýèèèä óóààòààíà ïó
àçðýí òýìæýýãýð ïèèòýà èè òíà àíèãíð òààààèàìæèéí ààéàóóèèààùí ççðýã,
òççìèéã òýðýãæççýð журам;

14.6.13. өдөөéí ýð äýýð, ãóðààààã- ýðäýýàèéí àðèà ñíìèððèèùí òèèà ààíñ
íýýèäýí àçðòäýñýí ñóóðó çýò òààñíó òíí ïó àðèèæààíà ààéãàà òààààèàìæèéí
àè-àèéí òííã ïèèòñýí ààéð íðèèèèä òàíãàð òàèààððè òààààèàìæèéí
ààéàóóèèààùí ççðýã;

14.6.14. cóóðó çýò òààñíó ïðèãí àíèíí áóñàà ò°èá°ðèèä àààð çýðýã
ñóóðó çýò òààñààð äýð-èýããñýí ýððýý òààààèàìæèéí àè-èä ýçýìèèä-
ðýðýãæççýðýä òààðàèààòàè çéè-èèäýý ççççýð òàèààððè òààààèàìæèéí
ààéàóóèèààùí ççðýã;

14.6.15. cóóðó çýò òààñíó ïðèãí àíèíí áóñàà ò°èá°ðèèä òààààèàìæèéí
àè-èä ýçýìèèä-èä ïèãíð òóãàòàà;

14.6.16. эй дорөөéí 14.6.15-ä çààñàí ïðèãí àíèíí áóñàà ò°èá°ðèèä
íèãíðàí òààààèàìæèéí àè-èä ààðààã-èéí àààð çéè-èèäýýýíèè òèòäýýèèéí äýýä
òýçãààð, òèéíðçç òèòäýè àààð çýäýñýè;

14.6.17. хààààèàìæèéí àè-èä ýçýìèèä-èéí °íí ñóóðó çýò òààñ ààðààã-
ççðýä òçèýýæ ààéãàà ýñýð òóòàè ÿäýýýè;

14.6.18. òààààèàìæèéí àè-àèèä òààààèàð, àçðòäýð, òççìèé ýðð
òèèæñýíèèä àçðòäýð æóðàí;

14.6.19. cóóðó çýò òààñààð äýð-èýããñýí ýððèèä òýðýãæççýð
çðèèèãíð òààààèàìæèéí àè-èä ýçýìèèä-àèéí æàãñààèòóã ààðààð æóðàí,
òóãàòàà;

14.6.20. òààààèàìæèéí àè-àèèä òóãààð íðèèè, æóðàí;

14.6.21. áóñàà ÿäýýýè.

14.7. Хадгаламжийн бичиг гаргагч болон суурь үнэт цаас гаргагч хоорондын
эрх, үүрэг, хариуцлагыг тэдгээрийн хооронд байгуулсан гэрээгээр тодорхойлох
бөгөөд уг гэрээ нь хадгаламжийн бичгийн танилцуулгын салшгүй хэсэг байна.

14.8. Энэ хуулийн 14.7-д заасан гэрээнд дор дурдсан зүйлийн талаар заавал
тусгасан байх ба гэрээнд тусгаагүй нь тухайн хадгаламжийн бичгийг нийтэд санал
болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхээс татгалзах үндэслэл болно:

14.8.1. суурь үнэт цаасаар гэрчлэгдсэн хадгаламжийн бичиг
эзэмшигчийн өмчлөх эрхийн тухай;

14.8.2. хадгаламжид байх суурь үнэт цаасны тоо, хэмжээ нь нийтэд
арилжигдах хадгаламжийн бичгийн тоо, хэмжээнээс багагүй байх, суурь үнэт
цаасан тулгуурлан давхар өөр бусад үнэт цаас гаргах буюу өмчлөх эрхэд
өөрчлөлт оруулаагүй тухай;

14.8.3. суурь үнэт цаас нь харъяалах хөрөнгийн биржид бүртгэлтэй хэвээр буюу нийтэд арилжаалах эрх бүхий байгаа тухай;

14.8.4. хадгаламжийн бичиг эзэмшигчид суурь үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлүүлэх, санал өгөх, өгсөн саналын дүнг танилцуулах журам;

14.8.5. *с*óóðü çìýò òààñ íü ðóáüòàà áíë òççìëé ààáóó ñàíàë °ã°ð æóðìííí òàëààð òààààëàìæëéí àë-ëã ýçýìøëã-ýýñ òààààëàìæëéí áàëãóóëëààà çààààð °ã°ð æóðàì, òã çààààðò íëéòççìýí òóòàéí ðóáüòààíü ààáóó ñàíàëüí ýððýý ðýðýãæççìýð í°ò°ëëëã íü òàíãàð, òççìí-ëýí òààààëàìæëéí àë-ãëéí ààáóó °ãñ°í ñàíàëüí äçìã òàíëëòóóëã òàëààðòë òààààëàìæëéí áàëãóóëëààüí ççìýã;

14.8.6. н^еéòýä ^еë òíä áíëãíãíë çíðëð ìýäýýëëëã òààààëàìæëéí áàëãóóëëààä ^íýò òààñíü çàð çýýëëéí òóòàé ðóóëü тогтоомж áíëí Õíðíííí òíãòíííí æóðìííí ààáóó, ðóààòààíä íü ìýäýýýð áíëíëòííä òàíãàð òàëààðòë ñóóðü çìýò òààñ äàðãàã-ëéí ççìýã;

14.8.7. х^аããàëàìæëéí áàëãóóëëààä нь ýýý ðóóëëéí 14.8.6-ä çààñàí ìýäýýëëëã ñóóðü çìýò òààñ äàðãàã-ààñ òççìýí ààñíü äàðãàãëéí àëëüí °ã°ð òààòààí íëéòýä ^еë òíä áíëãíð ççìýãðýã çààð;

14.8.8. үçðãýý áëãççìýýãçé áóðó çíðëð ñíð áëãççìýýãçé òààààëàìæëéí áàëãóóëëààä áíëíí ñóóðü çìýò òààñ äàðãàã-ëéí òààààëàìæëéí àë-ëã ýçýìøëã-ëéí °í° òççìýð ççìýã, хариуцлага;

14.8.9. х^аããàëàìæëéí àë-ëã ýçýìøëã-ëéí ç°ã°ð°ëãçéãýýð äýðýýä òóòàëæ áíëíðãçé тухай çохицуулалт.

14.9. Нэг хадгаламжийн бичигт нэгээс доошгүй суурь үнэт цаасыг гэрчилсэн байна. Энэ заалт хадгаламжийн бичгийг хуваахад нэг адил хамаарна.

14.10. Õààààëàìæëéí àë-ëã ýçýìøëã- íü òççìã òíðëðò òíííí ñóóðü çìýò òààñíü òààààëàìæëéí áàëãóóëëàààñ òççìýí ààñàí òíðëíãíëä òóòàéí ýçýìøëã-ëéí ðóáüä òààààëàìæëéí àë-ëã áóóñãàààð áíëíí. Äýðãýý òààààëàìæëéí àë-ëã äàðãàð òóòàë øëëããýðò çààñàí ýððýëòýä áàëð òààààëàìæëéí àë-ãëéí äýýä ðýìæýý °ð-ë°ãã°ðãçé.

14.11. Õààààëàìæëéí àë-ëã äàðãàã-òààààëàìæëéí áàëãóóëëààä íü °ðëéí áàëãóóëëààüí áíëíí ñóóðü çìýò òààñ äàðãàã-ëéí óëëðëüí òàëëàí, çìýò òààñíü çàð çýýëëéí çìý, àðëëæààíü ðýìæýý, ýãòàà í°ë°ë°ð ìýäýýëëëã ýýý ðóóëüä çààñàí æóðìààð ìýäýýýð ççìýãðýé.

14.12. Хадгаламжийн бичгийг гаргах эсхүл хадгаламжийн бичгийг дуусгавар болгох зорилгоор хадгаламжийн бичиг гаргагч-хадгаламжийн байгууллагын гадаад улсад нээсэн түүний өмчлөл дэх хадгаламжийн данснаас Монгол Улсад тусгайлан нээсэн хадгаламжийн данс хооронд суурь үнэт цаасыг шилжүүлэхэд тухайн суурь үнэт цаасны төлбөр төлөгдсөн байхыг шаардахгүй.

14.13. Энэ хуулийн 14.12-т заасан гүйлгээ нь орлогын албан татвар ногдуулах гүйлгээнд хамаарахгүй.

15 дугаар зүйл. Гадаад улсын хадгаламжийн бичиг

15.1. Гадаад улсын хадгаламжийн бичиг гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх хөрөнгийн биржийн бүртгэлд хамрагдсан суурь үнэт цаасыг эрх бүхий үнэт цаасны хадгаламжийн, эсхүл кастодийн үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллагад хадгалуулж, уг үнэт цаасанд тулгуурлан бусад улсын үнэт цаасны зах зээлд арилжаалах зорилгоор гаргасан хадгаламжийн бичгийг ойлгоно.

15.2. Гадаад улсын хадгаламжийн бичиг нь тухайн хадгаламжийн бичгийг арилжих зах зээл, улсаас хамаарч тухайлан нэршсэн нэртэй байж болно.

15.3. Өөрийн гаргасан үнэт цаасанд тулгуурлан гадаад улсын хадгаламжийн бичиг гаргахаар шийдвэрлэсэн үнэт цаас гаргагч нь шийдвэрээ шийдвэр гаргасан өдрөөс хойш ажлын тав хоногийн дотор нийтэд болон Хороо, хөрөнгийн биржид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

15.4. Энэ хуулийн 15.3-т заасан шийдвэрт дор дурдсан зүйлийг тусгана:

15.4.1. хадгаламжид шилжүүлж буй үнэт цаасны тоо, хэмжээ;

15.4.2. нэгж хадгаламжийн бичгийн гэрчлэх суурь үнэт цаасны тоо, хэмжээ;

15.4.3. хадгаламжийн бичиг эзэмшигчийн эрх, үүрэг;

15.4.4. хадгаламжийн бичиг гаргах ажиллагаанд оролцож буй эрх бүхий хадгаламжийн эсхүл кастодианы үйлчилгээ үзүүлэх байгууллагын талаарх мэдээлэл, түүний эрх, үүрэг;

15.4.5. хадгаламжийн бичгийг байршуулах /арилжих/ гадаад улсын холбогдох хөрөнгийн бирж;

15.4.6. Хороо болон хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлэл.

15.5. Өөрийн гаргасан суурь үнэт цаасанд тулгуурлан гадаад улсын хадгаламжийн бичиг гаргахаар шийдвэрлэсэн суурь үнэт цаас гаргагч нь дор дурдсан мэдээллийг нийтийн хүртээл болгох үүрэгтэй:

15.5.1. хадгаламжийн бичиг гаргах тухай байгуулсан гэрээ, хэлцэл;

15.5.2. энэ хуулийн 15.4-т заасан мэдээлэл;

15.5.3. хадгаламжийн бичиг гаргах ажиллагааны явцын талаарх мэдээллийг зохих журмын дагуу мэдээлэх.

15.6. Энэ хуулийн 14.9-14.13 дах хэсэг гадаадын хадгаламжийн бичиг гаргах ажиллагаанд нэг адил хамаарна.

16 дугаар зүйл. Компанийн өрийн бичиг

16.1. Зохих шалгуурыг хангасан компани өрийн бичиг гаргаж болно.

16.2. Компанийн өрийн бичиг нь эргэн төлөгдөх барьцаа эсхүл гуравдагч этгээдийн гаргасан баталгаатай байж болно.

16.3. Өрийн бичиг гаргах компанид тавигдах шалгуур, өрийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгох нарийвчилсан журмыг Хороо тогтооно.

16.4. Хөрөнгийн бирж Хорооноос тогтоосон шалгуурыг дордуулалгүйгээр өөрийн шалгуурыг тогтоож болно.

16.5. Компанийн гаргах өрийн бичигийн үнийн дүн нь тухайн компанийн өөрийн хөрөнгөөн үнийн дүнгээс ихгүй буюу тухайн өрийн бичиг гаргагч компанийн өөрийн хөрөнгө болон гуравдагч этгээдийн гаргасан баталгааны нийлбэр дүнгээс ихгүй байна.

16.6. Компанийн өрийн бичиг нь өрийн бичгийн эргэн төлөгдөх хугацаанаас өмнө буцаан татах нөхцөлтэй байж болно.

16.7. Компанийн өрийн бичгийг тогтоосон хугацааны дараа эсхүл тодорхой нөхцлийн үндсэн дээр хувьцаанд хөрвөх нөхцөлтэйгөөр гаргаж болно.

17 дугаар зүйл. Монгол Улсад бүртгэлтэй компани гадаад улсад үнэт цаасаа худалдах

17.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хөрөнгийн биржид үнэт цаасаа анхлан бүртгүүлсэн компани нийт гаргасан үнэт цаасныхаа 90 хүртэл хувьтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг гадаад улсын үнэт цаасны зах зээлд нэгэн зэрэг худалдаж болно.

17.2. Энэ хуулийн 17.1-д заасан компани гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа худалдахдаа Хорооноос зөвшөөрөл авна.

17.3. Энэ хуулийн 17.2-д заасан зөвшөөрөл олгох журмыг Хороо тогтооно.

18 дугаар зүйл. Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсын зохицуулттай үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа худалдах

18.1. Гадаад улсын аль нэг хөрөнгийн биржид анхлан бүртгүүлсэн хуулийн этгээд Хорооны зөвшөөрөлтэйгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй хөрөнгийн биржид үнэт цаасаа бүртгүүлэх буюу худалдаж болно.

18.2. Гадаад улсын хуулийн этгээд үнэт цаасаа Монгол Улсад худалдахдаа үнэт цаасны танилцуулгадаа өөрийн улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийн ижил болон зөрүүтэй зохицуулалтын талаар заавал тусгах ба эрх зүйн зохицуулалтын улмаас үүсэх эрсдлийн талаар, хувьцаа эзэмшигчдэд эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зохицуулалтыг заавал тусгана.

18.3. Монгол улсын зохицуулалттай зах зээлд үнэт цаасаа худалдаж болох гадаад улс, хөрөнгийн биржийн жагсаалт болон тухайн гадаад улсын үнэт цаас гаргагчид тавигдах шалгуурыг Хороо тогтооно.

18.4. Энэ хуулийн 18.1-д заасан зөвшөөрөл олгох журмыг Хороо тогтооно.

19 дүгээр зүйл. Үүсмэл санхүүгийн хэрэгслийг гаргах, худалдах

19.1. Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргаж болно.

19.2. Үүсмэл санхүүгийн хэрэгслийг гацхүү үнэт цаасны зах зээлд үнэт цаасны брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд болон мэргэжлийн хөрөнгө оруулагчийн хүрээнд худалдана.

19.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, худалдахад энэ хуулийн 19.1, 19.2 дахь заалт хамаарахгүй.

19.4. Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавигдах шалгуур, нөхцөл, шаардлага болон гаргах, худалдах журмыг Хороо тогтооно.

20 дугаар зүйл. Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүрэг

20.1. Үнэт цаас гаргагч дараахь нийтлэг үүрэгтэй байна:

20.1.1. үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн зохих журмын дагуу үнэт цаас гаргах;

20.1.2. үнэт цаас гаргагчийн тухай болон түүний гаргасан үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд Хороонд хүргэх, нийтэд мэдээлэх;

20.1.3. Компанийн тухай хуульд зааснаас цөөнгүй хараат бус гишүүнтэй байх;

20.1.4. тохиромжтой этгээдийг эрх бүхий албан тушаалтнаар томилох буюу сонгох;

20.1.5. үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг гагцхүү танилцуулгад заасан төслийн зориулалтын дагуу зарцуулах, төслийн хэрэгжилт танилцуулгад заасан хуваариас өөрчлөгдөх тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;

20.1.6. хагас жилийн болон Хорооноос эрх авсан аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай¹ хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон Хөрөнгийн биржид хүргэх;

20.1.7. Хорооноос тогтоосон журмын дагуу тайлангийн хураангуйг аудиторын дүгнэлтийн хамт хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

20.1.8. үнэт цаас нь бүртгэлтэй хувьцаат компани хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын материалыг гаргасан шийдвэрийн хамт 6

¹ Нягтлан бодох бүртгэлийн тухай –“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

дугаар сарын 1-ний дотор, ээлжит бус хурлын материалыг хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор Хороонд хүргэх;

20.1.9. гаргасан үнэт цаасны үнэт нөлөөлөх мэдээллийг шуурхай нийтэд мэдээлэх;

20.1.10. Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмуудыг биелүүлэх.

20.2. Үнэт цаасны үнэ, арилжааны хэмжээ, идэвхэд нөлөөлөх мэдээллийн төрөл, түүнийг олон нийтэд хүргэх журмыг Хороо тогтооно.

21 дүгээр зүйл. Үнэт цаас гаргагчтай холбоотой мэдээлэл шаардах

21.1. Дараахь нөхцөл байдал үүссэн эсхүл үүсч болзошгүй гэж үзвэл Хороо үнэт цаас гаргагч болон түүнтэй холбоотой бусад этгээдээс тогтоосон хугацаанд, зохих арга хэлбэрээр мэдээлэл ирүүлэхийг шаардах эрхтэй:

21.1.1. өөрийн болон бусад этгээдийн үүрэг гүйцэтгүүлэгчийг хууран мэхлэх, залилах болон бусад хууль бус үйл ажиллагаа явуулсан буюу явуулж байгаа, хувьцаа эзэмшигчид шударга бус хандсан;

21.1.2. хууран мэхлэх, залилах болон бусад хууль бус зорилгоор компанийг үүсгэн байгуулсан;

21.1.3. компанийн үүсгэн байгуулагч, эрх бүхий албан тушаалтан үүсгэн байгуулах, удирдлагыг хэрэгжүүлэхдээ тухайн компани, түүний хувьцаа эзэмшигчийг хууран мэхэлсэн болон бусад хууль бус ажиллагаа явуулсан;

21.1.4. хувьцаа эзэмшигчдэд хүргэвэл зохих мэдээллийг хүргээгүй.

21.2. Хороо энэ хуулийн 21.1-т заасан эрхийн хэрэгжилтийг өөрийн хянан шалгагчаар гүйцэтгүүлж болно.

21.3. Хороо, түүнээс эрх олгосон хянан шалгагч энэ хуулийн 21.1-т заасан мэдээллийг уг мэдээллийг эзэмшиж байгаа гэж үзсэн аливаа этгээдээс шаардах эрхтэй.

21.4. Энэ хуулийн 21.1-т заасан эрхэд баримтыг хуулбарлан авах, шаардлагатай гэж үзсэн зарим хэсгийг буюу бүгдийг эхээр нь авах, компанид ажиллаж байсан буюу ажиллаж байгаа этгээдээс тайлбар гаргуулах, хэрвээ баримтыг гаргаж өгөөгүй бол түүнийг гаргаж өгөх үүрэгтэй этгээдээс хаана, хэнд байгаа талаар бодит мэдээлэл шаардах эрх нэгэн адил хамаарна.

22 дугаар зүйл. Үнэт цаас гаргагчийн хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд нэхэмжлэл гаргах

22.1. Үнэт цаас гаргагч, эсхүл түүний эрх бүхий албан тушаалтан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироосон, хууль бус үйл ажиллагаа явуулсан бөгөөд шаардлагатай гэж үзвэл Хороо хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

22.2. Үнэт цаас гаргагч, эсхүл түүний эрх бүхий албан тушаалтан тухайн компани болон хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан гэж үзвэл шүүх дараахь шийдвэрийг гаргана:

22.2.1. хохирол учруулж буй үйл ажиллагааг зогсоох;

22.2.2. зөрчигдсөн эрхийг сэргээхэд шаардлагатай арга хэмжээг шүүхийн шийдвэрт заасан нөхцлийн дагуу авч хэрэгжүүлэх;

22.2.3. эрх хүлээн авагч, эсхүл хөрөнгө эрхлэн хамгаалагчийг томилох, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлж, цалин урамшууллын хэмжээг тогтоох;

22.2.4. компани эсхүл тодорхой хувьцаа эзэмшигч бусад хувьцаа эзэмшигчдээс хувьцааг худалдан авахыг даалгах, компани худалдан авч байгаа тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг багасгах, эсхүл компанийг хуваах, татан буулгах зэрэг компанийн цаашдын үйл ажиллагааг зохицуулахад тохиромжтой гэж үзсэн шийдвэрийг гаргах.

22.3. Шүүхийн шийдвэрээр үнэт цаас гаргагчийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй зөрчилдсөн аливаа нэмэлт, өөрчлөлтийг дүрэмд оруулахыг хориглоно.

23 дугаар зүйл. Үнэт цаас гаргагчид даалгавар өгөх

23.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчлийг арилгах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Хороо тодорхой арга хэмжээ авах хугацаатай даалгаврыг үнэт цаас гаргагчид өгч болно.

23.2 Энэ хуулийн 23.1-т заасан даалгаврыг хүлээн авсан компани түүнийг заавал биелүүлэх үүрэгтэй.

23.3. Энэ хуулийн 23.1-д заасан даалгаврыг зохих ёсоор биелүүлээгүй компани, түүний албан тушаалтны талаар Хороо шүүхэд гомдол гаргах замаар албадан биелүүлүүлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

КОМПАНИЙГ ХУДАЛДАН АВАХ

Гуравдугаар дугаар дэд бүлэг

Компанийг худалдан авах санал гаргах

24 дүгээр зүйл. Компанийг худалдан авах санал гаргах

24.1. Компанийг худалдан авах саналыг дараахь хэлбэрээр гаргана:

24.1.1. компанийн хувьцаа эзэмшигч дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран, эсхүл хувьцаа эзэмшдэггүй аливаа этгээд

тухайн компанийн хувьцааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн худалдан авахаар сайн дурын үндсэн дээр;

24.1.2. компанийн хяналтын багцыг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхээр үлдсэн бүх хувьцааг худалдан авахаар заавал.

24.2. Компанийг худалдан авах санал гаргагч этгээд нь энэ тухайгаа Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авна.

24.3. Компанийг худалдан авах санал гаргагч нь компанийн хувьцааг худалдан авахыг хувьцаа эзэмшигчдэд санал болгохдоо Компанийн тухай хуульд заасан журмыг баримтлах бөгөөд худалдан авалттай холбоотой мэдээллийг сонирхогч бүх этгээдэд нэг адил хүргэнэ.

24.4. Компанийг худалдан авах талаар нийтэд хүргэх мэдээлэлд дор дурдсан зүйлийг тусгасан байна:

24.4.1. компанийг худалдан авах санал гаргагчийн нэр;

24.4.2. нийт худалдан авахаар санал болгож байгаа хувьцааны тоо хэмжээ болон нэг хувьцааг худалдаж авах үнийн доод хэмжээ;

24.4.3. хувьцаа худалдан авах хөрөнгийн эх үүсвэр;

24.4.4. компанийг хөгжүүлэх төсөл, санал.

24.5. Компанийг худалдан авах саналын хүчинтэй байх доод хугацаа хоёр сар, дээд хугацаа зургаан сар байна.

24.6. Компанийг худалдан авахаар санал гаргагчийн хувьцаа худалдан авахаар санал болгож буй үнийг тухайн хувьцааны сүүлийн зургаан сарын дундаж ханш, хэрэв санал гаргагч нь хувьцаа эзэмшигч бол түүний тухайн компанийн хувьцааг худалдан авсан дээд ханш хоёрын аль өндрөөс доошгүй байхаар тогтоох бөгөөд уг үнэ тухайн хувьцааны нэрлэсэн үнээс доогуур байж болохгүй.

24.7. Компанийг худалдан авах санал гаргагч нь Хороонд худалдан авах санал гаргахыг хүссэн өргөдөл гаргахдаа тухайн компанийн нийт хувьцааны таваас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч болон компанийн төлөөлөн удирдах зөвлөлд энэ тухай мэдэгдсэн байна.

25 дугаар зүйл. Компанийг худалдан авах үйл ажиллагаа

25.1. Компанийг худалдан авах санал гаргах, түүнтэй холбоотой үйл ажиллагааны журмыг Хороо тогтооно.

25.2. Энэ хуулийн 25.1-д заасан журамд дараахь зүйлийг тусгасан байна:

25.2.1. санал болгох арга, хэлбэр;

25.2.2. саналыг бүртгүүлэх хүсэлт гаргах, зөвшөөрөх, зөвшөөрөхөөс татгалзах үндэслэл;

25.2.3. саналаа нийтэд мэдээлэх журам;

25.2.4. компанийн удирдлагаас худалдан авах саналтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээ;

25.2.5. санал гаргах ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ;

25.2.6. санал болгохтой холбоотой баримт, бичгийн агуулга, нийтэд толилуулах, мэдээлэх хугацаа;

25.2.7. санал болгох үйл ажиллагааны хугацаа;

25.2.8. санал болгохоос өмнө болон санал болгох ажиллагаа түүний явцад арилжаанд тавих хязгаарлалт;

25.2.9. худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх баталгаа;

25.2.10. үнэт цаасны брокер, үнэт цаасны зөвлөх, компанийн ажилтан, санал гаргагч болон уг үйл ажиллагаанд оролцож байгаа бусад талуудын үйл ажиллагааг шалгах;

25.2.11. санал болгох үйл ажиллагаанд оролцож байгаа талуудад шаардлага өгөх;

25.2.12. энэ хууль, Хорооноос тогтоосон журамд заасан тодорхой шаардлага буюу үүргээс аль нэг талыг чөлөөлөх Хорооны бүрэн эрх;

25.2.13. нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс нийтэд хүргэх мэдээлэл;

25.2.14. компанийг худалдан авах үйл ажиллагаанд хориглох зүйл;

25.2.15. компанийг худалдан авах үйл ажиллагааг зохистой явуулахад шаардлагатай гэж Хороо үзсэн бусад асуудал.

25.3. Хорооноос тогтоосон журмыг зөрчиж худалдан авах санал гаргах, эсхүл санал гаргалгүй компанийг худалдан авахад чиглэсэн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

25.4. Компанийн саналын эрхтэй бүхий хувьцааг худалдан авах үүрэгтэй этгээд уг үүргээ биелүүлээгүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж буй хувьцаанаас хууль зөрчиж өөрийн өмчлөлд шилжүүлэн авсан бүх хувьцаа саналын эрхгүй болох бөгөөд уг хувьцааг албадан худалдана.

25.5. Энэ хуулийн 25.4-д заасан албадан худалдах ажиллагааг хэрэгжүүлэх журмыг Хороо тогтооно.

25.6. Компанийн хяналтын багцыг худалдан авч заавал худалдан авах санал гаргах үүрэг хүлээсэн этгээдийн уг үүргийн талаарх мэдээллийг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага хяналтын багц хувьцааг худалдан авснаас хойш тав хоногийн дотор Хороонд мэдэгдэх ба олон нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх үүрэгтэй.

25.7. Саналын эрхгүй болсон хувьцааны талаарх мэдээллийг Хороо өөрийн цахим хуудсаар дамжуулан 15 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ

ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дөрөвдүгээр дэд бүлэг

Нийтлэг зохицуулалт

26 дугаар зүйл. Зохицуулалттай үйл ажиллагаа

26.1. Үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай үйл ажиллагаанд дор дурдсан үйл ажиллагаа хамаарна:

26.1.1. үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа;

26.1.2. үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа;

26.1.3. үнэт цаасны зөвлөхийн үйл ажиллагаа;

26.1.4. үнэт цаасны удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа;

26.1.5. андеррайтерийн үйл ажиллагаа;

26.1.6. үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа;

26.1.7. үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа;

26.1.8. үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа;

26.1.9. үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа;

26.1.10. кастодианы үйл ажиллагаа;

26.1.11. үнэт цаасны арилжаа зохион байгуулах үйл ажиллагаа;

26.1.12. зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа;

26.1.13. зохицуулалттай үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа;

26.1.14. зохицуулалттай үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх ажиллагаа;

26.1.15. зохицуулалттай үнэт цаасны зах зээлийн оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх ажиллагаа;

26.1.16. хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөлтэй эрхлэхээр заасан буюу Хорооноос зохицуулалттай гэж тогтоосон бусад үйл ажиллагаа.

26.2. Энэ хуулийн 26.1.1-23.1.12, 26.1.16-д заасан үйл ажиллагааг гагцхүү Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.

26.3. Энэ хуулийн 26.1.13-26.1.14-т заасан үйл ажиллагааг тухайн үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий этгээд Хорооноос тогтоосон нөхцөл шаардлагыг ханган, Хороонд бүртгүүлсний үндсэн дээр эрхэлнэ.

27 дугаар зүйл. Зохицуулалттай үйл ажиллагаанд баримтлах зарчим

27.1. Зохицуулалттай этгээд нь үйл ажиллагаандаа дараахь зарчмыг баримтална:

27.1.1. хууль тогтоомж, дүрэм, журам болон нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг чанд баримтлах;

27.1.2. харилцагчид үйлчилгээ үзүүлэхээсээ өмнө түүний хөрөнгө оруулалтын зорилго, боломжийн талаар зохих журмын дагуу судалж мэдсэн байх;

27.1.3. хөрөнгө оруулалтын үндэслэл бүхий шийдвэр гаргахад нь шаардагдах мэдээлэл, зөвлөгөөгөөр харилцагч бүрийг хангах;

27.1.4. харилцагчтай болон бусад этгээдтэй сонирхлын зөрчил үүсгэхээс зайлсхийх, зөрчил үүссэн тохиолдолд харилцагчид даруй мэдэгдэх;

27.1.5. харилцагчийн ашиг сонирхлоос дээгүүр хувийн ашиг сонирхлоо тавихгүй байх, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглахгүй байх;

27.1.6. харилцагч тус бүрийн хөрөнгийг тусгаарлан, найдвартай байдлыг ханган зохистой хадгалах;

27.1.7. тухайн үйл ажиллагааг эрхлэх, эрсдлийг даван туулахад хүрэлцэхүйц санхүүгийн эх үүсвэртэй байх;

27.1.8. дотоод үйл ажиллагаагаа зохистой хэлбэрээр зохион байгуулж, дотоод хяналтыг бүрдүүлж ажиллах;

27.1.9. үйл ажиллагаатай холбоотой анхан шатны бүртгэл, баримтыг зохистой түвшинд хөтлөх, найдвартай хадгалах;

27.1.10. ажлын байрны шаардлагыг хангасан хүний нөөцтэй байх, ажилтнуудын чиг үүргийг оновчтой тодорхойлж, гүйцэтгэлд нь зохих хяналт тавьдаг байх.

28 дугаар зүйл. Зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм

28.1. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэн явуулахтай холбоотой харилцааг Хорооноос баталсан багц дүрээр зохицуулна.

28.2. Зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм нь дор дурдсан дүрэм журам, аргачлал, заавар, нөхцөл шаардлага, хэм хэмжээнээс бүрдэнэ:

28.2.1. зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай журам;

28.2.2. зохицуулалттай этгээдэд тавигдах нөхцөл, шаардлага, тэдгээрийн төлбөрийн чадварыг тодорхойлох аргачлал, шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам;

28.2.3. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн эрсдлийн сан, нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ, сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхэд тавигдах нөхцөл, шаардлага болон санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам;

28.2.4. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн үйлчилгээний хураамжийн дээд хязгаар;

28.2.5. зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавигдах шаардлага, төлөвлөгөөг боловсруулах аргачлал, тайлагнах журам;

28.2.6. Хороонд ирүүлэхээр болон нийтэд мэдээлэхээр тогтоосон мэдээллийг Хороонд ирүүлэх, нийтэд мэдээлэх, түүнд хяналт тавих журам;

28.2.7. зохицуулалттай этгээд өөрөө, эсхүл түүний нэрийн өмнөөс төөрөгдүүлсэн, хуурамч зар сурталчилгаа явуулахыг хориглох тухай журам;

28.2.8. үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх, үзүүлсэн үйлчилгээг баримтжуулах журам, заавар;

28.2.9. үйлчлүүлэгч, харилцагчид эрсдлийн талаар мэдээлэх өгөх заавар, журам;

28.2.10. зохицуулалттай этгээд, харилцагч хоорондын сонирхлын зөрчлийг зохицуулах журам;

28.2.11. харилцагчийн даалгавар, захиалгыг хүлээж авах, биелүүлэх журам;

28.2.12. зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтныг томилох, тохиромжтой этгээдийг тодорхойлох журам;

28.2.13. үнэт цаасны зах зээлд оролцогч хуулийн этгээд төрийн бус архивын баримтыг хадгалах, шилжүүлэх журам;

28.2.14. зохицуулалттай этгээдаас тайлан, мэдээ, өргөдөл, хүсэлт гаргах заавар;

28.2.15. зохицуулалттай этгээд салбар, төлөөлөгчийн газар нээх, тэдгээрт тавигдах нөхцөл, шаардлага;

28.2.16. үйл ажиллагаагаа бүхэлд нь эсхүл тодорхой хэсгийг нь бусдад шилжүүлэх, эсхүл нэгтгэх журам;

28.2.17. Дампуурлын тухай хууль⁴, Компанийн тухай хуулиас гадуур зохицуулалттай этгээдийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх журам;

28.2.18. зохицуулалттай этгээдээс төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;

28.2.19. зохицуулалттай этгээдээс тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай болон холбоотой этгээдийн талаар мэдээлэх журам.

28.3. Хороо нь энэ хуулийн 28.2-т зааснаас гадна зохицуулалттай үйл ажиллагааны төрөл тус бүрээр тусгай зохицуулалт бүхий хэм хэмжээг тогтооно.

Тавдугаар дэд бүлэг

Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх

29 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах

29.1. Энэ хуулийн 26.1.1-23.1.12, 26.1.16-д заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүссэн хуулийн этгээд тогтоосон маягтын дагуу Хороонд өргөдөл гаргана.

29.2. Энэ хуулийн 29.1-д заасан өргөдөлд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай¹ хуульд зааснаас гадна дараахь баримт бичгийг хавсаргана:

29.2.1. эрхлэх үйл ажиллагааны төрөл;

29.2.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн баталгаажуулсан хуулбар;

29.2.3. үүсгэн байгуулагчид, эсхүл хувь нийлүүлэгчдийн талаарх тодорхойлолт, тэдгээрийн төлбөрийн чадвар, банк санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй тухай тодорхойлолт, тохиромжтой этгээд болох тухай мэдээлэл;

29.2.4. хуулийн этгээдийн санхүүгийн эх үүсвэр, чадавхи, хувь нийлүүлсэн, өөрийн хөрөнгийн болон эргэлтийн хөрөнгийн доод хэмжээг хангасан тухай баримт;

29.2.5. мэргэжил, мэргэшлийн дадлага туршлагатай, тухайн үйл ажиллагааг зохих ёсоор эрхлэн явуулах боловсон хүчнээр хангагдсан тухай баримт;

29.2.6. тухайн үйл ажиллагааг явуулах ажлын байр, техник, тоног

⁴“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1998 оны №1

¹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай –“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

төхөөрөмжийн шаардлагыг хангасан тухай баримт;

29.2.7. тухайн үйл ажиллагааг эрхлэн явуулах гурваас доошгүй жилийн бизнесийн болон эрсдлийн менежментийн төлөвлөгөө;

29.2.8. тусгай зөвшөөрөл авах эрх бүхий болохыг нотлох баримт;

29.2.9. Хорооноос тогтоосон бусад баримт, мэдээлэл.

29.3. Банк, түүний хараат болон охин компани эсхүл банктai холбоотой хуулийн этгээд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлхээр хүсэлт гаргаж байгаа тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчөөс тусгай зөвшөөрөл авахыг зөвшөөрсөн тухай албан бичгийг энэ хуулийн 29.1-д заасан өргөдөлд хавсаргана.

29.4. Үнэт цаасны арилжааны төлбөр, тооцооны эсхүл үнэт цаасны хадгаламжийн, кастодианы үйлчилгээ эрхэлх тусгай зөвшөөрөл авахыг хүсч буй хуулийн этгээдийн тухайд Хөрөнгийн биржийн арилжааны цахим сүлжээнд хэрхэн холбогдсон талаархи дэлгэрэнгүй танилцуулгыг энэ хуулийн 29.1-д заасан өргөдөлд хавсаргана.

29.5. Үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүсч байгаа хуулийн этгээдийн тухайд үнэт цаасны арилжааны төлбөрийн болон тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагын цахим сүлжээнд хэрхэн холбогдсон талаархи дэлгэрэнгүй танилцуулгыг энэ хуулийн 29.1-д заасан өргөдөлд хавсаргана.

30 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

30.1. Өргөдөл гаргагч нь дараахь нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд Хороо тусгай зөвшөөрөл олгоно:

30.1.1. тухайн хуулийн этгээд холбогдох зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэхэд түүний бусад үйл ажиллагаа нь зөрчилдөхгүй, сонирхолын зөрчил үүсхээргүй байна гэж үзсэн;

30.1.2. тусгай зөвшөөрөл олгоход тохиромжтой этгээд болох нь тогтоогдсон;

30.1.3. хүний нөөцийн хувьд Хорооноос тогтоосон шаардлага хангасан;

30.1.4. Хорооноос тогтоосон хэмжээнээс доошгүй хэмжээний хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгөтэй;

30.1.5. ажлын байр, техник, тоног төхөөрөмж, програм хангамж нь тухайн үйл ажиллагааг эрхлэх шаардлагыг бүрэн хангасан;

30.1.6. Хорооноос тогтоосон бусад нөхцөл, шаардлагыг хангасан.

30.2. Тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар олгох бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахын өмнө дараагийн жилийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлсөн бол тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааг дахин нэг жилээр сунгасанд тооцно.

30.3. Тусгай зөвшөөрөл бүхий тухайн үйл ажиллагааг эрхлэх нөхцөл, шаардлагыг хангаагүй гэж үзвэл Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана.

30.4. Хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдээс бусад этгээд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх буюу эрхэлж байгаа мэтээр бусдыг төөрөгдүүлэхийг хориглоно.

30.5. Тусгай зөвшөөрөлд тухайн хуулийн этгээдийн эрхэлж болох үйл ажиллагааны төрлийг заах бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд тусгай зөвшөөрөл аваагүй бусад үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.

31 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

31.1. Дараахь тохиолдолд Хороо тусгай зөвшөөрлийг гурав хүртэл сарын хугацаагаар эсхүл тогтоосон шаардлагыг хангах хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно:

31.1.1. өөрөө хүсэлт гаргасан;

31.1.2. энэ хууль, Хороо, арилжаа эрхлэх болон үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоо, хадгаламжийн байгуулагаас тогтоосон журмыг зөрчсөн;

31.1.3. тусгай зөвшөөрөл, эрхийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл хангахгүй болсон;

31.1.4. Хорооноос өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

31.1.5. Хорооноос шаардсан мэдээллийг өгөөгүй, дутуу мэдээлэл өгсөн эсхүл худал, төөрөгдүүлсэн, мэдээлэл өгсөн;

31.1.6. хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр тухайн үйл ажиллагааг эрхлэхэд тохиромжтой этгээд биш болсон;

31.1.7. тогтоосон хугацаанд зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төлөөгүй.

31.2. Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн хуулийн этгээд Хорооноос тогтоосон хугацаанд түдгэлзүүлэх болсон зөрчлийг арилгаж, тусгай зөвшөөрөлөө сэргээлгэх тухай хүсэлтээ Хороонд ирүүлнэ.

31.3. Хороо энэ хуулийн 31.2-д заасан хүсэлтийг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

31.4. Сэргээсэн тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө хүчинтэй байсан хугацаанаас түдгэлзүүлсэн хугацааг хасч үлдэх хугацаагаар тогтооно.

32 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

32.1. Дор дурдсан тохиолдолд Хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

32.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

32.1.2. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг Хороонд ирүүлээгүй;

32.1.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа эсхүл ноцтой зөрчсөн;

32.1.4. харилцагчдаа их хэмжээний хохирол учруулсан;

32.1.5. тухайн хуулийн этгээд дампуурсан эсхүл татан буугдсан;

32.1.6. хуульд заасан бусад нөхцөл байдал үүссэн.

32.2. Хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийг сэргээхгүй.

33 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн буюу хүчингүй болгосноос үүсэх үр дагавар

33.1. Хороо энэ хуулийн 29, 30 дүгээр зүйлд заасан шийдвэрээ тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлэх бөгөөд шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

33.1.1. шийдвэрийн үндэслэл;

33.1.2. шийдвэр хүчин төгөлдөр болох хугацаа;

33.1.3. шийдвэр гарсантай холбогдуулан үүссэх үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, даалгавар.

33.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон нь тухайн хуулийн этгээдээс бусадтай өмнө байгуулсан хүчин төгөлдөр гэрээ, хэлцлийг дуусгавар болгох буюу уг гэрээ хэлцлээр хүлээсэн үүргийг биелүүлэх, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

33.3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн буюу хүчингүй болгосон тохиолдолд тухайн хуулийн этгээд Хорооноос зөвшөөрснөөс бусад аливаа гэрээ хэлцэл, гүйлгээ хийхийг хориглоно. Гагцхүү харилцагчийн ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай үйл ажиллагаа явуулахыг Хороо зөвшөөрч болно.

33.4. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон хугацаанд Хорооны зөвшөөрөлгүй байгуулсан аливаа гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байх бөгөөд уг хүчин төгөлдөр бус гэрээний улмаас бусдад учруулсан хохирлыг тухайн хуулийн этгээд, эсхүл гэм буруутай этгээд хариуцна.

33.5. Тусгай зөвшөөрөлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон нь тухайн хуулийн этгээдийг болон түүний холбогдох албан тушаалтныг иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

34 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосонтой холбоотой Хорооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээ

34.1. Хороо нь тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн болон хүчингүй болгосон тухай шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын гурван хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

34.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд харилцагчдад үйлчилгээ үзүүлэх болон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд харилцагчийг эрх бүхий бусад хуулийн этгээдэд шилжүүлэх ажиллагааг Хороо тогтоосон журмынхаа хүрээнд авч хэрэгжүүлнэ.

34.3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд Хороо шаардлагатай гэж үзвэл хуулийн этгээдийн зүгээс түүний харилцагчийн дансанд нэвтрэх, аливаа гүйлгээ хийх эрхийг хязгаарлах, тухайн хуулийн этгээдийн эд хөрөнгө, мөнгөн хөрөнгийг битүүмжлэх, тусгаарлах арга хэмжээг тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд авч болно.

34.4. Тусгай хүчингүй болгосон тохиолдолд харилцагчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Хороо нь тухайн хуулийн этгээдээс харилцагчийн данс, мөнгөн хөрөнгөд нэвтрэх, аливаа гүйлгээ хийх эрхийг хязгаарлах болон тухайн эрхэлж байсан үйл ажиллагаатай нь холбоотой баримтыг битүүмжлэх, зохих архивт шилжүүлэх, хуулийн этгээдийн хөрөнгийг битүүмжилэх зэрэг арга хэмжээг авч болно.

34.5. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон хуулийн этгээд нь өөр бусад үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш ажлын 45 хоногийн дотор татан буугдах эсэх асуудлаа эрх барих байгууллагаараа хэлэлцэн шийдвэрлэх үүрэгтэй.

34.6. Энэ хуулийн 34.5-д заасан хугацаанд татан буулгах эсэхээ шийдвэрлээгүй хуулийн этгээдийг албадан татан буулгахаар Хороо шүүхэд хандана.

35 дугаар зүйл. Бүртгэлийн үндсэн дээр зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэх

35.1. Эрх бүхий хуулийн этгээд энэ хуулийн 26.1.13-26.1.14-т заасан үйл ажиллагааг гагцхүү Хороонд бүртгүүлсний үндсэн дээр эрхэлнэ.

35.2. Энэ хуулийн 26.1.13-26.1.14-т заасан үйл ажиллагааг эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх ажиллагааг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохион байгуулна.

35.3. Үнэт цаасны зах зээлд энэ хуулийн 26.1.13-26.1.14-т заасан холбогдох үйл ажиллагааг эрхлэх хүсэлтэй хуулийн этгээд, түүний ажилтан нь дор дурдсан шалгуурыг заавал тус тус хангасан байна:

35.3.1. хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн тухайд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр байнга ажиллах тогтоосон тооны хуульчтай байх ба хуульч нь хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх;

26.3.2. хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тухайд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр байнга ажиллах

тогтоосон тооны үнэлгээчинтэй байх ба үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээний хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх;

35.3.3. аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн тухайд хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр байнга ажиллах тогтоосон тооны аудиторчтой байх ба аудиторч нь аудитын үйл ажиллагаа эрхлэн явуулах хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байх;

35.4. Хороо бүртгэл хамрагдах хуулийн этгээдэд тавих нөхцөл шаардлагыг үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага, тухай бүрийн мэргэжлийн төрийн бус байгууллагын саналыг харгалзан тогтооно.

35.5. Хороо бүртгэлд хамрагдах хүсэл бүхий хуулийн этгээдэд зориулсан мэргэжлийн сургалтыг холбогдох мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

35.6. Хороо бүртгэл хамрагдахаар ирүүлсэн хүсэлтийг ажлын 15 хоногийн дотор шийдвэрлэнэ.

35.7. Хороо бүртгэлд бүртгэгдсэн хуулийн этгээд тухайн үйл ажиллагааг тодорхой цаг хугацааны хязгааргүйгээр эрхэлнэ.

35.8. Хороо дор дурдсан тохиолдолд бүртгэлд бүртгэхээс татгалзана:

35.8.1. тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаагүй;

35.8.2. тухайн хуулийн этгээд уг үйлчилгээг үзүүлэх санхүү, төлбөрийн чадвар хангалтгүй;

35.8.3 боловсон хүчний хувьд тухайн үйлчилгээг үзүүлэх дадлага, туршлага, мэдлэг нь хангалтгүй гэж үзсэн.

35.9. Хороо дор дурдсан тохиолдолд хуулийн этгээдийг бүртгэлээс хасна:

35.9.1. тухайн хуулийн этгээд хүссэн;

35.9.2. холбогдох үйлчилгээг зохих журам, стандартын дагуу үзүүлээгүй, мэрэгжлийн ноцтой алдаа гаргасан;

35.9.3. хууль зөрсөн болох нь тогтоогдсон.

35.9. Хороо бүртгэлээс хассан хуулийн этгээдийг таван жилийн дотор дахин бүртгэхгүй.

36 дугаар зүйл. Гомдол гаргах эрх

36.1. Энэ хуулийн 30.3, 31.1, 32.1, 35.7, 35.8-д заасан Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

36.2. Энэ хуулийн 36.1-т заасны дагуу гомдол гаргасан нь Хорооны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй бөгөөд гагцхүү Хяналтын зөвлөлийн шийдвэрээр Хорооны шийдвэрийн биелэлтийг түр түдгэлзүүлж болно.

36.3. Хяналтын зөвлөл 36.1-т заасан гомдлыг хянаад дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

36.3.1. Хорооны шийдвэрийг хүчингүй болгох;

36.3.2. Хорооны шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгох;

36.3.3. Хорооны шийдвэрт шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт оруулах.

36.4. Хяналтын зөвлөл нь энэ хуулийн 35.3.1, 35.3.3-т заасан шийдвэрийг гаргасан тохиолдолд тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар Хороонд чиглэл өгнө.

36.5. Хяналтын зөвлөлөөс гаргасан хууль ёсны шийдвэрийг Хороо хүлээн авч, хэрэгжүүлэх үүрэгтэй. Хяналтын зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд хандаж болно.

Зургадугаар дэд бүлэг

Зохицуулалттай ажил, үйлчилгээ эрхлэх мэргэжилтэнд эрх олгох

37 дугаар зүйл. Мэргэжилтэнд эрх олгох

37.1. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд ажиллах мэргэжилтэн нь энэ зүйлд заасны дагуу Хорооноос эрх авсан байна.

37.2. Мэргэжилтэнд олгох эрх нь эрхлэх ажил үүргийн төрөл, мэргэшлийн түвшингөөс хамаар тодорхой төрөл, зэрэглэлд хуваагдаж болно.

37.3. Энэ хуулийн 37.2-т заасан зохицуулалттай ажил, үйлчилгээ эрхлэх мэргэжилтэнд олгох эрхийн төрөл, зэрэглэлийг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн төрийн бус байгууллага болон өөрийгөө зохицуулах байгууллагын саналыг харгалзан Хороо тогтооно.

37.4. Хорооны дарга мэргэшлийн шалгаруулалтанд тэнцсэн иргэнд Мэргэшлийн хорооны дүгнэлтийг үндэслэн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жилийн хугацаагаар олгоно.

37.5. Мэргэшлийн шалгаруулалтыг Хорооны дэргэдэх орон тооны бус Мэргэшлийн хороо /цаашид “Мэргэшлийн хороо” гэх/ эрхлэн гүйцэтгэнэ. Мэргэшлийн хороо нь есөн гишүүнтэй байна.

37.6. Мэргэшлийн хорооны гишүүн нь эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалт, эрх зүйн мэргэжлийн аль нэгийг эзэмшсэн байх ба мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг, өөрийгөө зохицуулах байгууллагаас гурав, Хорооноос томилсон таван хүний төлөөлөлийг оролцуулан, холбогдох байгууллагын саналыг үндэслэн Хорооны даргын тушаалаар тухай бүр батална.

37.7. Мэргэшлийн хороог Хорооны даргын томилсон Хорооны гишүүн даргална.

37.8. Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон журмыг Хороо тогтооно.

37.9. Мэргэшлийн шалгаруулалтад оролцох иргэн нь Хорооноос зохион байгуулсан эсхүл мэргэжлийн байгууллагын эсхүл өөрийгөө зохицуулах байгууллагаас зохион байгуулдаг Хорооны хүлээн зөвшөөрсөн сургалтад хамрагдаж зохих шалгуурыг хангасан байна.

Долоодугаар дэд бүлэг

Зохицуулалттай үйл ажиллагааны төрөл

38 дугаар зүйл. Брокерийн үйл ажиллагаа

38.1. Харилцагчийн хөрөнгөөр, түүний нэрийн өмнөөс тодорхой үнэт цаасыг худалдан авах, эсхүл бусдад худалдахтай холбоотой үйлчилгээг харилцагчидтай байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлэхийг брокерийн үйл ажиллагаа гэнэ.

38.2. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бөгөөд энэ хуулийн 38.1-д заасан гэрээнд тусгайлан заасан бол брокер нь түүний харилцагч болох үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох үйлчилгээг үзүүлж болох бөгөөд нийтэд санал болгосон үнэт цааснаас борлогдоогүй үлдсэн үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр өөрийн нэр дээр худалдан авч болно.

38.3. Брокер нь хууль тогтоомж, Хороо болон харъяалах хөрөнгийн бирж, үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоо, хадгаламжийн байгууллага зэрэг гишүүнчлэл бүхий өөрийгөө зохицуулах байгууллагаас баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үүрэгтэй.

38.4. Брокер болон түүний харилцагчийн хоорондын харилцааг гэрээний үндсэн дээр зохицуулна. Брокерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний стандарт нөхцөл, гэрээ байгуулах журмыг Хороо тогтооно.

38.5. Брокер нь харицлагчийн даалгаврыг гэрээнд заасан нөхцөл, шаардлагын дагуу шударгаар гүйцэтгэх үүрэгтэй бөгөөд гэрээний нөхцөл өөрчлөгдөхөөр бол энэ тухай харилцагчид мэдэгдэж даалгаврыг шинэчлэх үүрэгтэй.

38.6. Брокер нь дилерийн үйл ажиллагаа давхар эрхэлж буй эсэхээс үл хамаарч харилцагчийн даалгаврыг тэргүүн ээлжинд биелүүлэх үүрэгтэй.

38.7. Брокер нь харилцагчтай брокерийн үйлчилгээ үзүүлэх талаар аливаа гэрээ байгуулахаас өмнө сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал байгаа эсэхийг урьдчилан, эсхүл гэрээ байгуулсны дараа сонирхолын зөрчил үүссэн бол тэр тухай харилцагчид шуурхай мэдэгдэх үүрэгтэй.

38.8. Харилцагчтай гэрээ байгуулахаас өмнө түүнд урьдчилан мэдэгдээгүй, эсхүл гэрээ байгуулсны дараа үүссэн сонирхолын зөрчлийн талаар шуурхай мэдэгдээгүйн улмаас тухайн харилцагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг тогтоосон журмын дагуу тухайн брокер өөрийн хөрөнгөөр хариуцна.

38.9. Брокер нь өөрийн харилцагчдын өмчлөл дэх мөнгөн хөрөнгийг мөнгөн хөрөнгийн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий, хараат бус санхүүгийн байгууллагаад харилцагч тус бүрийн нэр дээр данс нээн байршуулж, уг хөрөнгийг найдвартай хамгаалах үүрэгтэй бөгөөд харилцагчийн зөвшөөрөлгүй уг хөрөнгийг аливаа байдлаар захиран зарцуулахыг хориглоно.

38.10. Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол брокер нь өөрийн харилцагчтай байгуулсан гэрээний дагуу түүнээс хүлээн авсан, эсхүл түүний даалгавраар бусадтай байгуулсан гэрээний дагуу түүний нэр дээр бусдаас хүлээн авсан мөнгөн хөрөнгийг тухайн харилцагчийн нэр дээрх дансанд байршуулж ажиллах үүрэгтэй.

38.11. Брокерт байгаа харилцагчийн өмчлөл дэх хөрөнгөөс тухайн брокерийн бусдын өмнө хүлээсэн үүргийг гүйцэтгүүлж болохгүй.

38.12. Брокер нь харилцагчдаа үнэт цаасыг зээлээр худалдан авч өгөхөөр гэрээ байгуулсан эсхүл бусад байдлаар харилцагчийн өмнө төлбөрийн үүрэг хүлээснээс бусад тохиолдолд өөрийн хөрөнгийг харилцагчийн хөрөнгөтэй нийлүүлэх буюу хольж болохгүй.

38.13. Харилцагч нь өөрийн өмчлөл дэх хөрөнгөөс захиран зарцуулах эрхийг гэрээний үндсэн дээр өөрийн брокерт өгч болох ба гэрээнд уг хөрөнгийг буцаан төлөх үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, эсхүл батлан даалтын талаар заавал тусгана.

38.14. Энэ хуулийн 38.13-д заасан хөрөнгийг харилцагчийн зөвшөөрөл өгөөгүй бусад хөрөнгөөс тусгайлан өөр дансанд байршуулна.

39 дүгээр зүйл. Дилерийн үйл ажиллагаа

39.1. Өөрийн өөрийн хөрөнгөөр нэрийн өмнөөс тодорхой үнэт цаасыг тодорхой үнээр худалдан авах буюу худалдах саналыг нийтэд санал болгож, уг үнээр худалдах буюу худалдан авахаар хариу санал ирсэн нөхцөлд саналыг биелүүлэх үүрэг хүлээх замаар үнэт цаасны арилжаанд тогтмол оролцох ажиллагааг дилерийн үйл ажиллагаа гэнэ.

39.2. Дилер нь энэ хуулийн 39.1-д заасан үнэт цаасны үнээс гадна дор дурдсан нөхцлийг санал болгож болно:

39.2.1. худалдах буюу худалдан авах нийт үнэт цаасны дээд, доод хэмжээ;

39.2.2. нийтэд санал болгож буй үнийн хүчинтэй байх хугацаа;

39.2.3. хуулиар хориглоогүй бусад санал.

39.3. Дилер нь нийтэд санал болгосон саналаа анх санал гаргасан арга, хэлбэрээр өөрчлөх буюу хүчингүй болгож болно.

39.4. Дилерийн нийтэд санал болгосон хүчинтэй саналын дагуу үнэт цаасыг худалдах буюу худалдан авахаар хүлээн зөвшөөрсөн хариуг дилер үл маргах журмаар биелүүлэх үүрэгтэй.

39.5. Энэ хуулийн 39.4-д заасан үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөрөнгийн бирж дилерээс тодорхой хэмжээний барьцаа хөрөнгийг тусгай дансанд байршуулахыг шаардаж болно.

39.6. Дилер нийтэд санал болгосон саналаа биелүүлэхээс татгалзсаны улмаас бусдад учирсан хохирлыг шүүхийн журмаар нэхэмжилнэ.

40 дүгээр зүйл. Үнэт цаасны зөвлөхийн үйл ажиллагаа

40.1. Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үнийг тодорхойлоход шаардлагатай судалгаа, шинжилгээг гэрээний үндсэн дээр үнэт цаас гаргагчид гүйцэтгэж өгөх болон тодорхой харилцагчид үнэт цаасыг худалдах, эсхүл худалдан авах үнэ, нөхцөл, хугацааны талаар хөндлөнгийн, мэргэжлийн зөвлөгөөг төлбөртэйгөөр өгөх ажиллагааг үнэт цаасны зөвлөхийн үйл ажиллагаа гэнэ.

40.2. Өөрийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, эсхүл аль нэг хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгө оруулалтын шийдвэрт зориулан шинжилгээ, судалгаа хийх болон нийтийн хэрэгцээнд зориулан шинжлэх ухааны зорилгоор судалгаа, шинжилгээ хийх, дүнг нийтэд мэдээлэхийг үнэт цаасны зөвлөхийн үйл ажиллагаа явуулсан гэж үзэхгүй.

41 дүгээр зүйл. Үнэт цаасны удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

41.1. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр итгэмжлэгч-харилцагчийн өмчлөл дэх үнэт цаас, түүнтэй холбоотой хөрөнгийн удирдлагыг итгэмжлэгдсэн өмчлөгчийн хувиар хэрэгжүүлэх ажиллагааг үнэт цаасны удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэнэ.

41.2. Үнэт цаасны удирдлага хэрэгжүүлэгч болон түүний итгэмжлэгч-харилцагч хооронд, эсхүл тухайн үнэт цаасны удирдлага хэрэгжүүлэгчийн хэд хэдэн итгэмжлэгч-харицлагчдын хооронд үүссэн, урьдчилан мэдэгдээгүй сонирхолын зөрчлийн улмаас харилцагчдад учирсан хохирлыг үнэт цаасны удирдлага хэрэгжүүлэгч хариуцна.

41.3. Харилцагч нь мэргэжлийн хөрөнгө оруулагч байх тохиолдолд үнэт цаасны удирдлага хэрэгжүүлэгч нь үүсмэл үнэт цаастай холбоотой гэрээ хэлцэл хийж болно.

41.4. Үнэт цаасны удирдлага хэрэгжүүлэх ажиллагаа явуулах нарийвчилсан журмыг Хороо батална.

41.5. Хөрөнгө оруулалтын сангийн болон тэтгэврийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуульд нийцүүлэн гаргасан тусгай хуулиар зохицуулна.

42 дугаар зүйл. Андеррайтерийн үйл ажиллагаа

42.1. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний гаргаж буй үнэт цаасыг нийтэд санал болгох болон тэдгээр үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд байршуулахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ажиллагааг андеррайтерийн үйл ажиллагаа гэнэ.

42.2. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг брокерийн эсхүл дилерийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий, зохих шаардлагыг хангасан хуулийн этгээдэд Хороо олгож болно.

42.3. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн брокерийн, эсхүл дилерийн /хавсран эрхэлдэг бол хоёр тусгай зөвшөөрөл бүхэлдээ/ хүчингүй болох нь тухайн хуулийн этгээдийн андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

42.4. Андеррайтерийн үйлчилгээг дор дурдсан нөхцлийн аль нэгнээр үзүүлнэ:

42.4.1. хатуу буюу андеррайтер нь үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгож буй бүх үнэт цаасыг худалдан авах;

42.4.2. бүх хүчин чадлаараа хичээх буюу андеррайтер нь өөрийн хөрөнгө оруулагчиддаа тухайн үнэт цаасыг танилцуулах замаар тэдгээрийг борлуулахад шаардлагатай бүх хүчин чармалалт гаргах;

42.4.3. андеррайтер нийтэд санал болгосны дараа борлогдоогүй үлдсэн хэсгийг бүхэлд нь худалдан авах;

42.4.4. андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад нөхцөл.

42.5. Андеррайтер нь энэ хуулийн 42.4-т заасан үйлчилгээг дангаар эсхүл Хорооноос тогтоосон эрх бүхий хуулийн этгээдтэй хамтран үзүүлж болно. Энэ тохиолдолд талууд хамтран ажиллах гэрээ байгуулах ба гэрээнд дор дурдсан нөхцөлийг заавал тусгана:

42.5.1. андеррайтерийн үйлчилгээг хамтран үзүүлэх талуудын тус бүрийн гүйцэтгэх чиг үүрэг;

42.5.2. андеррайтерийн үйлчилгээг хамтран үзүүлэх талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хуваарилалт;

42.5.3. гэрээ хүчин төгөлдөр байх хугацаа.

42.6. Андеррайтерийн үйл ажиллагаа явуулах журам болон андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний стандарт нөхцлийг Хороо тогтооно.

43 дугаар зүйл. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа

43.1. Тодорхой үнэт цаасны талаар, түүний үнэт цаас гаргагчийн болон өмчлөгчийн талаар, уг үнэт цаасны өмчлөгч /итгэмжлэгдсэн өмчлөгч хамаарна/-өөс үнэт цаасны өмчлөх эрх хэрэгжүүлэх явцад хийсэн үйлдэл, үйл явцтай холбоотой мэдээллийг нэгдсэн журмаар цуглуулах, бүртгэх, хадгалах, зохих журмын дагуу бусдад мэдээлэх ажиллагааг үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа гэнэ.

43.2. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн сан гэж үнэт цаасыг өмчлөгч болон үнэт цаасны итгэмжлэгдсэн өмчлөгч тухай бүрийн өмчлөлд байгаа үнэт цаасны болон өмчлөгчийн талаар, түүний эрх, үүргийн талаарх мэдээллийг агуулсан нэгдсэн бүртгэлийн санг ойлгоно.

43.3. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээлэл, баримтыг хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд бүрэн бүтэн хадгалж, зохих журмын дагуу бусдад саадгүй гаргаж өгөх үүрэгтэй.

43.4. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг хуулийн этгээд эрхэлнэ.

43.5. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа явуулах журмыг Хороо тогтооно.

43.6. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй хуулийн этгээд нь өөрийн эрхэлж буй үнэт цаасны бүртгэлд байгаа бусдын өмчлөл дэх үнэт цаасыг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр дур мэдэн захиран зарцуулахыг хориглоно.

43.7. Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан үнэт цаасны өмчлөгчийн бүртгэлийн хуулбарыг жилд нэг удаа үнэ төлбөргүйгээр авч болох ба үүнээс бусад тохиолдолд үйлчилгээний төлбөрийг талуудын хооронд байгуулсан гэрээний дагуу тогтооно.

43.8. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлд худал, хуурамч болон дутуу мэдээлэл гаргаж өгсний улмаас учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

43.9. Үндэслэл бүхий тохиолдолд үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа явуулж буй этгээд тодорхой бүртгэлийг гүйцэтгэхээс татгалзах, бүртгэлийн ажиллагааг түдгэлзүүлж зохих мэдээллийг нягтлах, эсхүл эрх бүхий байгууллагаар шалгуулах эрхтэй.

43.10. Үнэт цаасыг өмчлөгч болон үнэт цаасны итгэмжлэгдсэн өмчлөгч нь өмчлөгчийн хувиар үнэт цаасны бүртгэлд гаргаж өгөх шаардлагатай мэдээллийг үнэн зөвөөр, шуурхай гаргаж өгөх үүрэгтэй.

43.11. Үнэт цаасыг зөвхөн нэг бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдтэй гэрээ байгуулах замаар бүртгүүлэх бөгөөд давхардуулан бүртгэхийг хориглоно.

43.12. Үнэт цаасны итгэмжлэгдсэн өмчлөгчийн нэр дээр үнэт цаасны бүртгэлийг хийх нь уг үнэт цаасны үндсэн өмчлөгч болох үнэт цаас итгэмжлэгчийн өмчлөх эрхийг хязгаарлахгүй бөгөөд үнэт цаасны итгэмжлэгдсэн өмчлөгчийн бусдын өмнө хүлээсэн үүргийг тэдгээр үнэт цаасаар гүйцэтгэхгүй.

43.13. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлсний төлөө авах төлбөрийн дээд хязгаарыг Хороо тогтооно.

44 дүгээр зүйл. Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа

44.1. Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа гэж тогтоосон хугацаанд зохион байгуулсан үнэт цаасны арилжааны дараа уг арилжаанд оролцогчдын хооронд байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу талуудын хүлээх төлбөрийн эрх, үүргийг гэрээ тус бүрээр болон нэгдсэн байдлаар тодорхойлж холбогдох санхүүгийн бүртгэл тооцооллыг хийж, холбогдох төлбөр хийгдэх бэлтгэлийг ханган, үнэт цаасны арилжааны төлбөр гүйцэтгэх даалгаврыг төлбөр гүйцэтгэх байгууллагад илгээж, төлбөр хийгдсэн тайлангийн дагуу зохих санхүүгийн бүртгэлийг гүйцэтгэн гүйлгээг баталгаажуулах, зохих мэдээллийг үнэт цаасны хадгаламж, бүртгэлийн байгууллагад илгээх ажиллагааг ойлгоно.

44.2. Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд үнэт цаасны арилжааны явцад хийгдсэн хэлцэл цуцлагдах эрсдлийг бууруулах зорилгоор тусгай сан байгуулж ажиллана.

44.3. Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааны журмыг Хороо тогтооно.

45 дугаар зүйл. Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа

45.1. Үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа гэж үнэт цаасны арилжаа явагдсаны дараа үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаас худалдан авагчийн тухайн үнэт цаасыг худалдан авсны төлбөрийг үнэт цаас худалдагчийн дансанд шилжүүлж, түүний дансанд байгаа зохих тооны үнэт цаасыг үнэт цаас худалдан авагчийн дансанд байршуулах ажиллагааг тусгай техник тоног төхөөрөмжид тулгуурлан үнэт цаасны хадгаламжийн болон мөнгөн хөрөнгийн хадгаламжийн байгууллага хооронд даалгавар илгээх замаар төлбөрийн гүйлгээг нэг дор тогтоосон хугацаанд гүйцэтгэх ажиллагааг ойлгоно.

45.2. Үнэт цаасны арилжааны төлбөрийн гүйлгээ нь нэг удаа гүйцэтгэгдэх ба түүнийг буцаахгүй.

45.3. Үнэт цаасны арилжааны тооцооны байгууллагаас ирүүлсэн даалгаврыг зохих журмын дагуу тогтоосон хугацаанд гүйцэтгэхэд холбогдох төлбөрийн гүйлгээ гүйцэтгэх боломжгүй байсан буюу зохих мөнгөн хөрөнгө эсхүл үнэт цаас холбогдох дансанд байршаагүй байсан тохиолдолд тухайн төлбөрийн гүйлгээг гүйцэтгэхгүй.

45.4. Энэ хуулийн 45.3-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд үнэт цаасны арилжааны төлбөрийн байгууллага нь зохих журмын дагуу үнэт цаасны тооцооны байгууллагад шуурхай мэдэгдэх ба үнэт цаасны арилжааны тооцооны байгууллага нь үнэт цаасны арилжааны байгууллагатай тооцоо нийлж даалгаварын талаар гарсан алдааг залруулах, эсхүл тухайн арилжааны гэрээг хүчингүй болгох шийдвэр гаргаж эргэж мэдэгдэнэ.

45.5 Энэ хуулийн 45.3, 45.4-т заасан төлбөрийн гүйлгээ хийх даалгаврыг гүйцэтгэх эсэх асуудлыг ажлын 1 хоногт багтаан шийдвэрлэх бөгөөд уг хугацаанд алдааг залруулаагүй бол тухайн арилжааны гэрээ болон түүнтэй холбоотой төлбөрийн гүйлгээний даалгаврыг хүчингүйд тооцоно.

46 дугаар зүйл. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа

46.1. Үнэт цаасыг хадгалах, хадгалагдаж буй үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа гэнэ.

46.2. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагааны журам, уг үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг Хороо тогтооно.

46.3. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагааг хуулийн этгээд эрхлэх бөгөөд үнэт цаасыг түүний өмчлөгчтэй бичгээр байгуулсан үнэт цаасны хадгаламжийн гэрээний үндсэн дээр хадгална.

46.4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны хадгаламжийн гэрээ нь үнэт цаас хадгалагчид түүнийг захиран зарцуулах эрхийг олгохгүй.

46.5. Үнэт цаасны хадгаламжийн гэрээнд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

46.5.1. хадгалуулж буй гэрээний зүйлийн тодорхойлолт;

46.5.2. хадгалагдаж буй үнэт цаасны талаар хадгалагчийн эдлэх эрх, үүрэг, түүнтэй холбоотой аливаа гүйлгээг хийх, гүйлгээ хийх зөвшөөрлийг үнэт цаас өмчлөгчөөс олгох журам;

46.5.3. гэрээ хүчин төгөлдөр байх хугацаа;

46.5.4. гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээний төлбөр, түүнийг төлөх журам;

46.5.5. хадгалж буй үнэт цаасны талаар үнэт цаасны өмчлөгчид тайлагнах журам;

46.5.6. бусад.

46.6. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд нь хадгалж буй үнэт цаасны талаар үнэт цаас гаргагчаас хүлээн авсан мэдээллийг тухайн үнэт цаас өмчлөгчид мэдээлэх, үнэт цаасны өмчлөлийн талаарх шилжилт хөдөлгөөний талаар үнэт цаасны бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдэд мэдээлж зохих бүртгэлд хамруулах болон үнэт цаасны өмчлөх эрхийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх үүрэгтэй.

46.7. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд харилцагчтай байгуулсан гэрээгээр харилцан тохиролцсон бол тодорхой үнэт цаасыг итгэмжлэгдсэн өмчлөгчийн хувиар өмчилж болно.

46.8. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь мөнгөн хөрөнгө хадгалах эрхгүй бөгөөд үнэт цаас хадгалуулагчийн өмчлөл дэх үнэт цаасны ногдол ашиг, ногдол хувь болон үнэт цаас худалдсаны төлбөрийг мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий санхүүгийн байгууллагад тухайн харилцагчийн нэр дээр нээсэн дансанд тусгайлан байршуулна.

46.9. Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргийг түүний хадгалж буй харилцагчийн дансандахь үнэт цаас болон түүнтэй холбоотой мөнгөн хөрөнгөөр гүйцэтгэхийг хориглоно.

47 дугаар зүйл. Кастодианы үйл ажиллагаа

47.1. Үнэт цаас өмчлөгчийн өмчлөл дэх үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг ханган хадгалах болон үнэт цаасаар гэрчлэгдсэн бусад эрхийг үнэт цаасны өмчлөгч хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг түүнд үзүүлэх ажиллагааг кастодианы үйл ажиллагаа гэнэ.

47.2. Кастодианы үйл ажиллагааг гагцхүү банкны үйл ажиллагаа явуулах эрх бүхий толгой компанитай, түүний хараат эсхүл охин компани эрхэлж болно.

47.3. Кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээд өөрт хадгалагдаж байгаа үнэт цаасны талаар өмчлөгчөөс бусад аливаа этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулах буюу захиран зарцуулахыг хориглоно.

47.4. Кастодиан үйл ажиллагаа явуулах журмыг Хороо тогтооно.

48 дугаар зүйл. Үнэт цаасны арилжаа зохион байгуулах үйл ажиллагаа

48.1. Үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой гэрээ байгуулах нөхцөлийг бүрдүүлэх үйлчилгээ үзүүлэх ажиллагааг үнэт цаасны арилжаа зохион байгуулах үйл ажиллагаа гэнэ.

48.2. Үнэт цаасны арилжаа зохион байгуулагч нь хөрөнгийн бирж байна.

48.3. Үнэт цаасны арилжаа зохион байгуулагч нь дор дурдсан мэдээллийг үнэ төлбөргүйгээр нийтэд мэдээлэх үүрэгтэй:

48.3.1. үнэт цаасны арилжаанд оролцох журам;

48.3.2. үнэт цаасны арилжаанд үнэт цаасыг оруулах журам;

48.3.3. үнэт цаасны арилжааны гэрээ байгуулах журам;

48.3.4. үнэт цаасны арилжааны гэрээг бүртгэх журам;

48.3.5. үнэт цаасны арилжааны гэрээг биелүүлэх журам;

48.3.6. үнэт цаасны үнэ хөөрөгдөхийг хориглох дүрэм;

48.3.7. үнэт цаасны арилжаа зохион байгуулах үйлчилгээ үзүүлэх хуваарь;

48.3.8. хууль тогтоомж, дотоод журмын дагуу нийтэд мэдээлэхээр заасан бусад мэдээлэл.

48.4. Үнэт цаасны арилжаа зохион байгуулагч нь үнэт цаасны арилжааны явцад байгуулагдсан үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ тус бүрийн талаар нийтэд мэдээлэх мэдээлэлд дор дурдсан зүйлийг тусгана:

48.4.1. гэрээ байгуулагдсан хугацаа, огноо, тухайн гэрээний бүртгэлийн дугаар;

48.4.2. тухайн гэрээний зүйл болох үнэт цаасны бүртгэлийн дугаар, ялгах тэмдэг;

48.4.3. арилжигдсан нэгж үнэт цаасны үнэ;

48.4.4. арилжигдсан нийт үнэт цаасны тоо;

48.4.5. хууль тогтоомж, дотоод журмын дагуу нийтэд мэдээлэхээр заасан бусад мэдээлэл.

49 дүгээр зүйл. Хөрөнгийн бирж

49.1. Хөрөнгийн бирж нь үнэт цаасны арилжаа зохион байгуулахаас гадна дор дурдсан үйл ажиллагааг эрхэлж болно:

49.1.1. валютын биржийн үйл ажиллагаа;

49.1.2. таваарын бирж / таваарын гүйлгээтэй холбоотой санхүүгийн хэрэгсэл арилжих/-ийн үйл ажиллагаа;

49.1.3. үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа;

49.1.4. үнэт цаасны чиглэлээр хэвлэн нийтлэх үйл ажиллагаа;

49.1.5. тогтоосон журмын дагуу үнэт цаасны арилжаа зохион байгуулах зорилгоор тодорхой эд хөрөнгийг төлбөртэй ашиглуулах.

49.2. Хөрөнгийн бирж энэ хуулийн 49.1-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

49.3. Хөрөнгийн бирж нь үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа хавсран эрхлэх тохиолдолд уг ажиллагааг эрхлэх тусгай нэгжтэй байна.

49.4. Хөрөнгийн биржийн удирдах, гүйцэтгэх болон хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч албан тушаалтан үнэт цаасны арилжаанд оролцогч зохицуулалттай хуулийн этгээдэд аливаа албан тушаал эрхлэхийг хориглоно.

49.5. Хөрөнгийн биржийн өөрийн нийт гаргасан үнэт цаасны 10-с дээш хувийг нэг этгээд буюу холбогдох этгээдүүд хамтран эзэмшихийг хориглоно.

49.6. Хөрөнгийн биржийн төлөөлөн удирдах зөвлөлд Хорооны төлөөллийг нийт саналын эрхийн 10-аас доошгүй хувийн саналын эрхтэйгээр оролцуулна.

49.7. Хөрөнгийн бирж нь тухайн хөрөнгийн биржийн арилжаанд оролцох үнэт цаасны бүртгэлийг хөтлөнө. Уг бүртгэлд үнэт цаасыг бүртгэх, бүртгэлээс хасах, бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааг мэргэжлийн бүртгэлийн зөвлөл гүйцэтгэнэ.

49.8. Хөрөнгийн биржийн бүртгэлийн зөвлөлийн гишүүн дор дурдсан асуудлаар саналын эрх эдлэхгүй:

49.8.1. тухайн үнэт цаасыг гаргагч өөрийн гаргасан үнэт цаасны бүртгэлтэй холбоотой асуудлаар;

49.8.2. тухайн үнэт цаас гаргагчтай холбогдох этгээд;

49.8.3. тухайн үнэт цаасыг гаргагч хуулийн этгээдэд ажилладаг, эсхүл түүний хараат, охин, зэргэлдээ компанид ажилдаг бол;

49.8.4. сонирхолын зөрчил бүхий бусад нөхцөл байдал бүхий бол.

50 дугаар зүйл. Хөрөнгийн биржийн арилжаанд оролцох

50.1. Хөрөнгийн биржийн арилжаанд гагцхүү эрх бүхий, тухайн хөрөнгийн биржид гишүүнчлэлтэй брокер, дилер оролцоно.

50.2. Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааг тухайн арилжаа зохион байгуулж буй байгууллагаас өөр байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд уг байгууллагыг хөрөнгийн биржийн арилжаанд оролцсон гэж үзэхгүй.

50.3. Энэ хуулийн 50.1-д зааснаас бусад этгээд хөрөнгийн биржийн арилжаанд эрх бүхий брокер, дилерээр зуучлуулан оролцоно.

51 дүгээр зүйл. Хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага

51.1. Хөрөнгийн бирж нь дор дурдсан нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй:

51.1.1. Хөрөнгийн биржийн арилжаанд оролцох болон хөрөнгийн биржийн арилжааны журмыг батлах;

51.1.2. үүсмэл үнэт цаас болон бараа таваарын гүйлгээнд тулгуурлан гаргасан үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжихад зохих үйлчилгээг үзүүлэх;

51.1.3. үнэт цаасыг хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэх, хасах болон арилжаанд оруулах журмыг батлах;

51.1.4. үүсмэл үнэт цаасыг бүртгэх, хасах болон арилжаанд оруулах журмыг батлах;

51.1.5. энэ хуульд заасны дагуу хөрөнгийн бирж батлахаар заасан дүрэм журмыг болон тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг зохих журмын дагуу Хороогоор батламжлуулах;

51.1.6. хөрөнгийн биржийн арилжааны явцад байгуулагдаж буй гэрээ бүрийг шалгах, хууль бус ажиллагаа явагдаж буй эсэхийг хянах;

51.1.4. хөрөнгийн биржийн арилжааг тогтоосон хугацаанд тасралтгүй, аливаа доголдолгүйгээр шударгаар зохион байгуулах, шаардлагатай бэлтгэлийг өөрийн эх үүсвэрээр бүрэн хангах;

51.2. Хөрөнгийн бирж нь энэ хуулийн 51.1.6-д заасан үүргээ биелүүлэх зорилгоор арилжаанд оролцогчид, үнэт цаас өмчлөгчид болон үнэт цаас гаргагчаас шаардлагатай мэдээллийг шаардах эрхтэй.

51.3. Хөрөнгийн бирж нь үзүүлж буй үйлчилгээнийхээ хөлс болон урамшууллын хэмжээгээ тогтоох эрхтэй.

52 дугаар зүйл. Зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа

52.1. Үнэт цаас гаргагчийн зээлжих чадварын зэрэглэлийг тусгайлан боловсруулсан арга, аргачлалд үндэслэн тогтоох хөндлөнгийн, хараат бус ажиллагааг зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа гэнэ.

52.2. Зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээд зохих нөхцөл, шаардлагыг хангасан бол үнэт цаасны зах зээл дэх тодорхой төрлийн санхүүгийн хэрэгсэлд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн чанар, эрсдэл, өгөөж зэрэг үзүүлэлтээр зэрэглэл тогтоож болно.

52.3. Зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь сонирхлын зөрчил бүхий үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх, хуурамч зэрэглэл тогтоох, дутуу мэдээлэл болон шинжилгээнд үндэслэн зэрэглэл тогтоохыг хориглоно.

52.4. Зээлжих чадварын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны журмыг Хороо тогтооно.

53 дугаар зүйл. Зохицуулалттай бусад үйл ажиллагаа

53.1. Хуульд заасан болон Хорооноос зохицуулалттай гэж тодорхойлсон бусад үйл ажиллагаа зохицуулалттай үйл ажиллагаанд хамаарна.

54 дүгээр зүйл. Зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхлэх

54.1. Дор дурдсан этгээд тус бүр дараахь үйл ажиллагааг хавсран эрхэлж болно:

54.1.1. брокерийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд дилерийн болон андеррайтерийн үйл ажиллагааг;

54.1.2. үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд үнэт цаасны арилжааны тооцооны болон төлбөрийн үйл ажиллагааг;

54.1.3. үнэт цаасны арилжаа зохион байгуулах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагааг;

54.1.4. тухай бүр Хорооноос зөвшөөрсөн үйл ажиллагаа.

54.2. Дор дурдсан үйл ажиллагааг хавсран эрхэлхийг хориглоно:

54.2.1. үнэт цаасны арилжаа зохион байгуулах үйл ажиллагааг үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн болон үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаатай;

54.2.2.....

54.3. Энэ хуульд заасан зохицуулалттай хэд хэдэн үйл ажиллагааг нэг хуулийн этгээд хавсран эрхлэх тохиолдолд тэдгээрт тавигдах санхүүгийн шаардлагыг хавсран эрхэлж буй үйл ажиллагаа тус бүрт тавигдах шаардлагаар нэмэгдүүлэн тооцно.

Наймдугаар дэд бүлэг

Нягтлан бодох бүртгэл, аудит

55 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэл хөтлөх

55.1. Зохицуулалттай этгээд нь тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаатай холбоотой хийсэн хэлцэл, өөрийн болон харилцагчийн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг бүрэн тусгасан анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, баланс орлого, үр дүнгийн тайланг цаг тухайд нь үнэн зөв гаргах үүрэгтэй.

55.2. Энэ зүйлд заасан бичиг баримт, бүртгэлийг өөрийн байгууллагад 5-аас доошгүй жил хадгалан архивт шилжүүлнэ. Эдгээр бичиг баримт, бүртгэлтэй Хороо, түүнээс томилогдсон этгээд танилцах, хуулбарлан авах эрхтэй.

56 дугаар зүйл. Аудитор

56.1. Зохицуулалттай этгээд нь тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг сарын дотор Хороонд бүртгүүлсэн аудиторыг сонгон гэрээ байгуулж, Хороонд мэдэгдэнэ.

56.2. Дараахь этгээдийг энэ хуулийн 56.1-т заасан аудиторроор томилохыг хориглоно:

56.2.1. зохицуулалттай этгээдэд эрх бүхий албан тушаал эрхэлж байсан буюу эрхэлж байгаа болон түүний хувьцаа эзэмшигч, эсхүл харилцагч;

56.2.2. энэ хуулийн 56.2.1-т заасан этгээдийн холбогдох этгээд;

56.2.3. Хорооноос эрх аваагүй аудитор.

56.3. Зохицуулалттай этгээд нь аудитортой гэрээ байгуулснаас хойш долоо хоногийн дотор түүний овог, нэр, хаяг байршлыг Хороонд бичгээр мэдэгдэнэ.

56.4. Зохицуулалттай этгээд нь аудиторыг чөлөөлсөн буюу аудитортой байгуулсан гэрээг дуусгавар болсноос хойш 7 хоногийн дотор энэ тухайгаа Хороонд бичгээр мэдэгдэнэ.

57 дугаар зүйл. Аудитийн шалгалт

57.1. Зохицуулалттай этгээд нь санхүүгийн жил дууссаны дараа нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитийн шалгалт хийлгэж, санхүүгийн тайлангийн аудитаар хянан баталгаажуулсан хувийг аудитийн дүгнэлтийн хамт дараа жилийн 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

57.2 Шалгалт хийх явцад зохицуулалттай этгээдийн санхүүгийн байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц болон санхүүгийн бусад зохицуулалтыг зөрчсөн нөхцөл байдал илэрвэл нэн даруй, ажлын 5 өдрөөс хэтрүүлэхгүйгээр Хороонд болон зохицуулалттай этгээдэд аудитор бичгээр мэдэгдэнэ.

57.3. Шаардлагатай гэж үзвэл Хороо улирлын тайланд аудит хийлгэхийг шаардаж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Үнэт цаасны зах зээлийн мэдээлэл

Есдүгээр дэд бүлэг

Үнэт цаасны зах зээлийн мэдээлэл

58 дугаар зүйл. Үнэт цаасны анхдагч зах зээлийн мэдээлэл

58.1. Анхдагч зах зээлд үнэт цаас гаргагч нь дор дурдсан мэдээллийг үнэ төлбөргүйгээр сонирхсон этгээдэд өгөх үүрэгтэй:

58.1.1. үнэт цаасны танилцуулгад туссан мэдээлэл;

58.1.2. үнэт цаас гаргагч компанийн дүрэм, журамд туссан үнэт цаас гаргах, үнэт цаасыг худалдах журам;

58.1.3. санхүүгийн тайлан;

58.1.4. Хороо, хөрөнгийн бирж болон бусад эрх бүхий байгууллагаас тогтоосон болон үнэт цаас гаргагчийн дүрэм, журамд нийтэд мэдээлэхээр тусгасан мэдээлэл.

59 дүгээр зүйл. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн мэдээлэл

59.1. Үнэт цаас гаргагч нь түүний гаргасан үнэт цаасыг үнэт цаасны хоёрдогч зах зээлд арилжааглагдаж байх хугацаанд Хороо, хөрөнгийн бирж, олон нийтэд хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нөлөөлж болохуйц өөрчлөлтийн талаар мэдээлэх үүрэгтэй.

59.2. Энэ хуулийн 59.1-д заасан мэдээлэлд дор дурдсан мэдээлэл хамаарна:

59.2.1. үнэт цаас гаргагчийн удирдах байгууллагын бүтцэд орсон өөрчлөлт;

59.2.2. нөлөө бүхий хувьцаа эзэмшигч саналын эрх бүхий хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн бүтцэд гарсан өөрчлөлт;

59.2.3. үнэт цаас гаргагч компанийн өөрчлөн байгуулалт, түүний охин, хараат болон зэргэлдээ компанид гарсан өөрчлөлт;

59.2.4. үнэт цаас гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан бол тэр тухай;

59.2.5. үнэт цаас гаргагч тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн эсхүл хүчингүй болгосон бол тэр тухай;

59.2.6. үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

59.2.7. нөлөө бүхий хувьцаа эзэмшигч 5 болон түүнээс дээш хувийг нь эзэмшиж буй бусад хуулийн этгээд дэх хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт;

59.2.8. үнэт цаасны үнэд нөлөөлж болох бусад мэдээлэл.

59.3. Үнэт цаас гаргагч нь энэ хуулийн 59.2-т заасан мэдээллийг үйл явдал болсноос хойш нэн даруй Хороо, хөрөнгийн бирж, нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх үүрэгтэй.

60 дугаар зүйл. Зохицуулалттай этгээдийн мэдээлэл

60.1. Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд дор дурдсан мэдээллийг зохих этгээдэд мэдээлэх үүрэгтэй:

60.1.1. харилцагчийн ашиг сонирхлыг хөндсөн мэдээллийг түүнтэй байгуулсан гэрээнд заасны дагуу гаргаж өгөх;

60.1.2. үнэт цаасны захиалга авах явцад нууцад хамаарахаас бусад тухайн үнэт цаасны тухай болон уг үнэт цаасыг гаргагчийн талаар өөрт байгаа мэдээллийг танилцуулах;

60.1.3. харилцагчиддаа тухайн үнэт цаасанд болон үнэт цаас гаргагчид эрх бүхий байгууллагаас тогтоосон хязгаарлалтын талаар болон тухайн үнэт цаасны тусгай нөхцлийн талаар танилцуулах;

60.1.4. харилцагчийн захиалгыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс татгалзсан бол түүний үндэслэлийг тайлбарлах;

60.1.5. хууль тогтоомжийн дагуу Хороонд мэдээлэх үүрэг бүхий үнэт цаастай холбоотой хийсэн хэлцэл, гүйлгээний талаар болон уг хэлцлийг байгуулсан буюу гүйлгээг хийлгэсэн харилцагчийн талаарх мэдээлэл;

60.1.6. харилцагчдад хүргэхээр ирүүлсэн мэдээллийг зохих харилцагчдад хүргэх;

60.1.7. Хорооноос тогтоосон журмын дагуу өөрийн байгууллагын талаарх зохих мэдээллийг харилцагчдаа өгөх;

60.1.8. өөрийн байгууллагын дүрэм, журамд хийсэн өөрчлөлтийг тогтоосон журмын дагуу Хороонд мэдэгдэх.

61 дүгээр зүйл. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын мэдээлэл

61.1. Хөрөнгийн бирж нь өөрийн бүртгэлд байгаа үнэт цаасны тухай болон түүнийг гаргагчийн талаарх нууцад хамаарахаас бусад бүх мэдээллийг сонирхогч этгээдэд гаргаж өгөх үүрэгтэй.

61.2. Хөрөнгийн бирж нь энэ хуулийн 61.1-д заасан мэдээллийг Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад боломжит мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүргэнэ.

61.3. Энэ хуулийн 61.1-д заасан мэдээллийг нийтэд хүргэх болон өөрийн гишүүдэд хүргэхтэй холбогдсон нарийвчилсан журмыг хөрөнгийн бирж өөрийн дотоод журмаар тогтооно.

62 дугаар зүйл. Хөрөнгө оруулагчийн мэдээлэл

62.1. Хөрөнгө оруулагч нь өөрийн өмчлөл дэх үнэт цаасны талаар үнэт цаасны бүртгэл хөтлөгч буюу итгэмжлэн удирдагчид өөрийн өмчлөл дэх үнэт цаастай холбоотой гарсан өөрчлөлтийн талаар зохих журмын дагуу мэдэгдэх үүрэгтэй.

62.2. Итгэмжлэн удирдуулах гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчийн зохих журмын дагуу гаргаж өгөөгүй мэдээллийн улмаас өөрт нь болон бусдад учирсан хохирлыг тухайн үнэт цаасыг итгэмжлэн удирдагч хариуцахгүй.

62.3. Хороо нь шаардлагатай гэж үзвэл шалгалтын явцад хөрөнгө оруулагчийн өмчлөл дэх үнэт цаасны талаар болон түүний холбогдох этгээдийн талаар мэдээлэл гаргаж өгөхийг шаардах эрхтэй.

63 дугаар зүйл. Хорооны мэдээлэл

63.1. Хороо нь өөрийн эрх хэмжээний хүрээнд дор дурдсан мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй:

63.1.1. үнэт цаасны танилцуулгын тухай

63.1.2. үнэт цаас гаргагчийн зүгээс Хороонд гаргасан тайлбар, тайлан, дүгнэлт;

63.1.3. тусгай зөвшөөрөл, эрх олгох, тэдгээрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох шийдвэр, түүний үндэслэлийн тухай;

63.1.4. Хорооны үйл ажиллагааны жилийн тайлан.

63.2. Хорооноос гадаадын зохицуулах байгууллага болон олон улсын байгууллагад мэдээлэл өгөхтэй холбоотой харилцааг энэ хуулийн 69 дүгээр зүйлийн дагуу зохицуулна.

64 дүгээр зүйл. Хороо бусдаас мэдээлэл авах

64.1. Хороо нь өөрийн чиг үүргийг зохих ёсоор гүйцэтгэх, шуурхай ажиллагаа явуулах зорилгоор иргэн, хуулийн этгээдээс шаардлагатай гэж үзсэн мэдээллийг шаардах эрхтэй.

64.2. Энэ хуулийн 64.1-д заасан мэдээлэлд нууц мэдээлэл хамаарах бөгөөд Хороо нууц мэдээллийг гагцхүү өөрийн албан хэрэгцээнд ашиглах ба өмчлөгчийн зөвшөөрөлгүй бусдад задруулахгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Аравдугаар дэд бүлэг

Үнэт цаасны зах зээл дэх төрийн зохицуулалт

65 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

65.1. Үнэт цаасны зах зээлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үнэт цаасны үйл ажиллагааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

65.1.1. үнэт цаасны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

65.1.2. үнэт цаасны зах зээлийн талаарх төрийн бодлогыг санхүү, эдийн засгийн нэгдсэн бодлоготой уялдуулан тодорхойлох, бодлогын зөвлөгөөгөөр Засгийн газрыг хангах;

65.1.3. Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах, түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

65.1.4. Засгийн газрын өрийн бичиг гаргах, үнэт цаасны зах зээлд Засгийн газрын өрийн бичгийн жишиг үнийг тогтоох;

65.1.5. Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Засаг даргаас гаргах өрийн бичигт баталгаа гаргах;

65.1.6. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

66 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээл дэх төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллага

66.1. Үнэт цаасны зах зээлийг төрөөс зохицуулах, хянах бүрэн эрхийг Хороо хэрэгжүүлнэ.

66.2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Хорооноос гаргасан шийдвэрийг үнэт цаасны зах зээлийн оролцогчид бүх этгээд биелүүлэх үүрэгтэй.

66.3. Хорооны эрх зүйн байдлыг энэ хууль болон санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

67 дүгээр зүйл. Төрийн зохицуулалтын зорилго

67.1. Энэхүү хуулийн хүрээнд төрөөс хэрэгжүүлэх үнэт цаасны зах зээлийн зохицуулалт нь дараахь зорилготой байна:

67.1.1. үнэт цаасны зах зээлд шударга, үр ашигтай, өрсөлдөөн бүхий, ил тод, дэг журамтай байдлыг хэвшүүлэх, дэмжих;

67.1.2. үнэт цаасны зах зээлийн талаархи иргэдийн боловсролыг дээшлүүлэх, түүнтэй холбоотой үйл ажиллагааг дэмжих;

67.1.3. үнэт цаасны зах зээлийн хөрөнгө оруулагч өөрийн гаргасан хөрөнгө оруулалтын шийдвэртэй холбоотой хариуцлагыг өөрөө хүлээх нийтлэг зарчмын хүрээнд тэдгээрийн эрх ашгийг зохих түвшинд хамгаалах;

67.1.4. үнэт цаасны зах зээл дэх гэмт хэрэг, зөрчлийг бууруулах;

67.1.5. үнэт цаасны зэх зээлийн системийн эрсдлийг бууруулах.

68 дугаар зүйл. Хорооны бүрэн эрх

68.1. Хороо нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

68.1.1. энэ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай гэж үзсэн арга хэмжээ авах, төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, дүрэм, журмыг батлан мөрдүүлэх;

68.1.2. үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, үнэт цаасны зах зээлд шударга, үр ашигтай, өрсөлдөөн бүхий, ил тод, дэг журамтай байдлыг хэвшүүлэхэд шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авах;

68.1.3. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тодорхойлох, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, нарийвчилсан журмыг батлах;

68.1.4. зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм журам, шалгуур үзүүлэлтийг тогтоох, уг шалгуур үзүүлэлтийг тооцох аргачлалыг батлах, хэрэгжилтийг хангуулах;

68.1.5. зохицуулаттай этгээдээс үйлчлүүлэгчидтэй байгуулах үнэт цаастай холбоотой гэрээ, хэлцэлд тавигдах нөхцөл, шаардлага болон гэрээ, хэлцлийн дагуу хүлээсэн үүргийн хэрэгжилтийг тайлагнах, дүгнэх журмыг батлах, хэрэгжилтийг хангуулах;

68.1.6. зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, хянах, шалгах, илэрсэн зөрчлийг арилгуулах, үүрэг, даалгавар өгөх, хариуцлага ногдуулах;

68.1.7. зохицуулалттай этгээдийн удирдах албан тушаалтанд нэр дэвшигчийг тохиромжтой этгээд мөн эсэхийг тогтоох, удирдах албан тушаалтнаар ажиллах зөвшөөрөл олгох, эсхүл тохиромжтой бус этгээдийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх;

68.1.8. Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтэд санал болгон худалдах дотоодын болон гадаадын хуулийн этгээдийн үнэт цаас цаас /үүнд үүсмэл үнэт цаас хамаарна/-ыг бүртгэх, нийтэд санал болгох, тэдгээрийг анхдагч болон хоёрдогч зах зээлд худалдахыг зөвшөөрөх, эсхүл тодорхой үнэт цаасыг худалдах, арилжих ажиллагааг түдгэлзүүлэх, зогсоох, үнэт цаастай холбоотой гүйлгээг түдгэлзүүлэх, зогсоох, үнэт цаасыг бүртгэлээс хасах,

68.1.9. үнэт цаас гаргагчид тавигдах нөхцөл, шаардлагыг тогтоох, энэ хуулийн 68.1.8-д заасан ажиллагааг явуулахтай холбогдсон журмыг батлах;

68.1.10. Монгол Улсын нутаг дэвсгэрт арижигдаж буй үнэт цаас болон үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдийн бүртгэлийг хөтлөх;

68.1.11. нийтэд заавал мэдээлэх мэдээллийг хэвлэн нийтлэх хэвлэл мэдээллийн хэрэгслийг тодорхойлох, тэдгээрийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох;

68.1.12. өөрийгөө зохицуулах байгууллага, үнэт цаасны арилжаа эрхлэх болон төлбөр, тооцоо, хадгаламжийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх дүрэм, журмыг батламжлах, Хороо болон нийтэд үйл ажиллагаагаа тайлагнах журмыг тогтоох;

68.1.13. хамтын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохицуулах;

68.1.14. үнэт цаасны зах зээлд аудит, үнэлгээ болон хууль зүйн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд эрх олгох;

68.1.15. компанийг худалдан авах саналыг сайн дурын үндсэн дээр болон заавал гаргах үйл ажиллагааг зохицуулах;

68.1.16. үнэт цаасны зах зээлийн үйлчлүүлэгч өөрийн гаргасан хөрөнгө оруулалтын шийдвэртэй холбоотой хариуцлагыг өөрөө хүлээх зарчмын хүрээнд тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад шаардагдах нөхцөл бүрдүүлэх;

68.1.17. үнэт цаасны зах зээл, хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэл, хариуцлагын талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх;

68.1.18. үнэт цаасны зах зээл дэх хууль бус, шударга бус үйл ажиллагааг зогсоох, урьдчилан сэргийлэх;

68.1.19. шаардлагатай гэж үзвэл үнэт цаас эзэмшигчийн нэрийн өмнөөс тэдгээрийн эрх ашгийн төлөө итгэмжлэлгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх ажиллагаанд оролцох;

68.1.20. гадаад улсын эрх бүхий зохицуулагч болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцан тусалцаа үзүүлэх;

68.1.21. хуулиар олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

69 дүгээр зүйл. Гадаад улсын зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, харилцан туслалцаа үзүүлэх

69.1. Хороо нь тус бүрийн чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэх, эсхүл тодорхой хяналт, шалгалтыг гүйцэтгэхэд харилцан туслалцаа үзүүлэх буюу шаардлагатай мэдээллийг харилцан солилцох зорилгоор гадаад улсын ижил чиг үүрэг бүхий зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагатай санамж бичиг, эсхүл гэрээ байгуулж болно.

69.2. Хорооноос гадаад улсын зохицуулагч байгууллага, эсхүл олон улсын байгууллагад туслалцаа үзүүлэх нь Монгол Улсын болон нийтийн ашиг сонирхолд харшлах буюу сөрөг нөлөө үзүүлэхээр байвал Хороо туслалцаа үзүүлэхээс татгалзана.

69.3. Хороо нь гадаад улсын зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагад туслалцаа үзүүлэхдээ энэ хуулийн 69.2-т заасан үндэслэлээс гадна уг хүсэлт гаргагч тал Хорооноос гарсан зардлыг нөхөн төлөх эсэх болон ижил төстэй хүсэлтийг Монголын талаас гаргах тохиолдолд хүсэлтийг хангах эрх хэмжээ тухайн байгууллагад байгаа эсэхийг харгалзан үзнэ.

69.4. Гадаад улсын зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллага нь Хорооноос туслалцаа хүсэхдээ түүний зорилго, мэдээллийг ашиглах зориулалт, нууцлалын талаар дурдсан байна.

69.5. Хорооноос өгсөн мэдээллийг зөвхөн хүсэлтэд дурдсан, эсхүл Хорооноос тогтоосон зорилгод ашиглах ба тус Хорооны зөвшөөрөлгүйгээр мэдээллийг бусад зорилгоор ашиглах буюу бусдад шилжүүлэх, задруулахыг хориглоно.

70 дугаар зүйл. Зөвлөмж гаргах

70.1. Хороо шаардлагатай гэж үзвэл олон нийт, өөрийгөө зохицуулах байгууллага, зохицуулалттай байгууллагад дор дурдсан асуудлаар зөвлөмж гаргах эрхтэй:

70.1.1. хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, анхааруулах, сэрэмжлүүлэх;

70.1.2. үнэт цаасны зах зээл дэх төрийн зохицуулалтын үр өгөөжийг дээшлүүлэх;

70.1.3. зохицуулалттай байгууллага болон мэргэжилтний үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх;

70.1.4. үнэт цаасны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

70.1.5. энэ хуульд заасан болон Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад асуудлаар.

70.2. Хороо нь зөвлөмжөө холбогдох этгээдэд бичгээр хүргүүлэхээс гадна шаардлагатай гэж үзвэл хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтийн хүртээл болгоно.

71 дүгээр зүйл. Даалгавар өгөх

71.1. Хороо нь дараахь тохиолдолд өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчид даалгавар өгөх эрхтэй:

71.1.1. харилцагч, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах шаардлага бий болсон;

71.1.2. тохиромжтой этгээдийн шаардлагыг хангахгүй болох нь тогтоогдсон, эсхүл хангахгүй болсон албан тушаалтныг тухайн албан тушаалаас нь чөлөөлөх шаардлага үүссэн;

71.1.3. зохицуулалттай этгээд нь энэ хууль, эсхүл энэ хууль болон түүнд нийцүүлэн Хорооноос тогтоосон хууль тогтоомжийн бусад актыг зөрчиж байгаа, зөрчсөн, эсхүл Хороонд буруу, худал, төөрөгдүүлсэн мэдээлэл өгснийг залруулах, зөрчлийг арилгах шаардлага үүссэн;

71.1.4. шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдол бий болсон.

71.2. Хорооны даалгавар нь дараахь нэг буюу хэд хэдэн хориг, шаардлагыг агуулсан байж болно:

71.2.1. хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, зөрчлийн үр дагаварыг арилгах;

71.2.2. тодорхой төрлийн хэлцэл хийхийг хориглох;

71.2.3. тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох;

71.2.4. үйл ажиллагаагаа тодорхой арга хэлбэрээр явуулахыг хориглох;

71.2.5. Монгол Улсад буюу гадаад улсад байгаа тодорхой хөрөнгийг захиран зарцуулахыг хориглох, зөвшөөрснөөс бусад зориулалтаар уг хөрөнгийг ашиглахгүй байхыг шаардах;

71.2.6. зохицуулалттай үйл ажиллагаанаас үүссэн үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор тодорхой хэмжээний хөрөнгийг Монгол Улсад байршуулахыг шаардах;

71.2.7. шаардлагатай гэж үзсэн бусад үйлдэл хийх.

71.3. Энэ хуулийн 71.1-д заасан даалгавар нь Хорооноос тогтоосон хугацаанд хүчинтэй байна.

71.4. Хорооноос өгсөн даалгаврыг хүлээн авсан хуулийн этгээд, мэргэжилтэн даалгаврыг тогтоосон хугацаанд заавал биелүүлж, гүйцэтгэлийг зохих журмын дагуу тайлагнах үүрэгтэй.

72 дугаар зүйл. Зохицуулалттай этгээдийг бүртгэх

72.1. Хороо зохицуулалттай этгээдийн бүртгэлийг хөтөлнө.

72.2. Зохицуулалттай этгээдийн бүртгэл хөтлөх журмыг Хороо батлах ба бүртгэлд зохицуулалттай этгээд бүрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл, түүнд гарсан өөрчлөлтийг тусгана.

72.3. Бүртгэл нь олон нийтэд нээлттэй байна.

73 дугаар зүйл. Тохиромжтой эсэхийг тодорхойлох

73.1. Тохиромжтой этгээдийг Хороо дор дурдсан болон **журмаар тогтоосон** нөхцлийг харгалзан тодорхойлно:

73.1.1. санхүүгийн байдал, төлбөрийн чадвар;

73.1.2. зохицуулалттай үйл ажиллагааг зохих мэргэжлийн түвшинд шударгаар гүйцэтгэх чадвар;

73.1.3. хувь хүн бол түүний мэргэжил, дадлага туршлага, өмнө хүлээж байсан хариуцлага, эрхэлж байсан ажил, санхүүгийн байдал нь уг албан тушаал эрхлэхэд тохиромжтой эсэх.

73.2. Хороо тохиромжтой этгээд мөн эсэхийг тогтоохдоо тухайн этгээдээс ирүүлсэн мэдээллээс гадна дараахь мэдээллийг харгалзана:

73.2.1. зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн уг үйл ажиллагааг явуулж байгаа ажилтан, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний нэрийн өмнөөс уг үйл ажиллагаа явуулж байгаа аливаа этгээдийн тухай мэдээлэл;

73.2.2. зохицуулалттай этгээд нь хуулийн этгээдийн нэгдлийн гишүүн бол тухайн нэгдэлд хамаарах бүх хуулийн этгээд, тэдгээрийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтны тухай мэдээлэл;

73.2.3. зохицуулалттай этгээд нь өөрийн үйл ажиллагааны дүрэм, журмыг тогтоосон, үр нөлөөтэй дотоод хяналтын болон эрсдлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн эсэх;

73.2.4. эрхэлж байгаа болон эрхлэх бизнесийн тухай.

73.3. Зохицуулалттай этгээд нь хуулийн этгээдийн нэгдлийн гишүүн бол Хороо нэгдлийн бусад гишүүдээс **шаардлагатай** мэдээллийг шаардан гаргуулж болно.

74 дүгээр зүйл. Хороо, түүний гишүүд, ажилтнуудын үйл ажиллагааны хууль зүйн баталгаа

74.1. Хороо, Хорооны дарга, гишүүд, хянан шалгагч, ажилтан нь энэ хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлж байхдаа санаатайгаар бусдад хохирол учруулснаас бусад тохиолдолд бусдад учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцахгүй.

74.2. Хорооны хянан шалгагч нь улсын байцаагчийн эрх хэмжээтэй байна.

74.3. Хорооны хянан шалгагчийн үйл ажиллагаанд төрийн хяналт шалгалтын тухай хууль тогтоомж нэг адил үйлчилнэ.

Арван нэгдүгээр дэд бүлэг

Үнэт цаасны зах зээл дэх төрийн бус, мэргэжлийн зохицуулалт

75 дугаар зүйл. Өөрийгөө зохицуулах байгууллага

75.1. Монгол Улсын үнэт цаасны зах зээлд өөрийгөө зохицуулах байгууллагын бүрэн эрхийг Хороонд бүртгэл бүхий төрийн бус байгууллага хэрэгжүүлнэ.

75.2. Энэ хуулийн 75.1-д заасан өөрийгөө зохицуулах байгууллага нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий зохицуулалттай хуулийн этгээд болон мэргэжилтнийг эгнээндээ нэгтгэсэн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагааны нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхийг дээшлүүлэх, зах зээлийг хөгжүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий төрийн бус, гишүүнчлэл бүхий, мэргэжлийн байгууллага байна.

75.3. Өөрийгөө зохицуулах байгууллагын бүрэн эрх нь Хороонд бүртгэгдсэнээр үүснэ.

75.4. Өөрийгөө зохицуулах байгууллага нь аймаг, нийслэлд салбартай байж болно.

75.5. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд болон эрх авсан мэргэжилтэн нь Хороонд бүртгэл бүхий аль нэг өөрийгөө зохицуулах байгууллагад заавал гишүүнчлэлтэй байна.

76 дугаар зүйл. Өөрийгөө зохицуулах байгууллагын бүрэн эрх

76.1. Өөрийгөө зохицуулах байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

76.1.1. үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр төрийн байгууллагад санал оруулах, тэдгээрийн боловсруулсан хууль тогтоомж, дүрэм, журмын төсөлд санал өгөх;

76.1.2. гишүүд хоорондын, эсхүл гишүүн болон үйлчлүүлэгч хооронд үүссэн маргааныг шүүхийн бус журмаар хянан шийдвэрлэх;

76.1.3. гишүүдийнхээ хүрээнд сургалт явуулах, давтан сургах;

76.1.4. мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаанд баримтлах нийтлэг журам, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, заавар, зөвлөмжийг

боловсруулах, тэдгээрийг Хороогоор батламжлуулсны үндсэн дээр хэрэгжилтийг нь хангах;

76.1.5. зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд судалгаа хийх, гишүүн байгууллагуудын хүрээнд зэрэглэл тогтоох, дүнг нийтэд мэдээлэх;

76.1.6. гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг шалгах, илэрсэн зөрчлийг арилгуулах, өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд гишүүддээ эд хөрөнгийн болон сахилгын хариуцлага хүлээлгэх, хуулийн хариуцлага хүлээлгэхээр бол зохих ажиллагааг гүйцэтгүүлэхээр холбогдох төрийн байгууллагад шилжүүлэх;

76.1.7. гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

76.1.8. гишүүдээ мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулах;

76.1.9. хуулийн хүрээнд Хорооноос зөвшөөрсөн бусад бүрэн эрх.

76.2. Өөрийгөө зохицуулах байгууллага нь хуульд заасны дагуу нууцад хамаарахаас бусад мэдээллийг өөрийн гишүүн байгууллагаас шаардан гаргуулах эрхтэй.

76.3. Өөрийгөө зохицуулах байгууллага нь түүний гишүүдийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хороо болон төрийн бусад эрх бүхий байгууллагаас ирүүлсэн аливаа мэдээллийг өөрийн гишүүн бүрт шуурхай хүргэх үүрэгтэй.

76.4. Өөрийгөө зохицуулах байгууллага нь өөрийн гишүүдийн үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх замаар өөрийн гишүүдийн харилцагчдын эрх ашгийг хамгаална.

76.5. Өөрийгөө зохицуулах байгууллага нь Хорооноос өгсөн даалгаврыг биелүүлэх үүрэгтэй.

77 дугаар зүйл. Өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэх

77.1. Хороо нь өөрийгөө зохицуулах байгууллагын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч, бүртгэх шийдвэр гаргахдаа дор дурдсан шалгуурыг үндэслэл болгоно:

77.1.1. нийт тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээдийн гучаас дээш хувийн гишүүнчлэлтэй байх;

77.1.2. Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд байх;

77.1.3. энэ хуулийн 78 дугаар зүйлд заасан нөхцөл, шаардлагад нийцсэн дүрэм, дотоод журамтай байх.

77.2. Энэ хуулийн 77.1-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд Хороо өөрийгөө зохицуулах байгууллагын бүртгэлд бүртгэхээс татгалзана.

77.3. Энэ хуулийн 77.1-т заасан шаардлагыг хангахгүй болсон, эсхүл Хороо өөрийгөө зохицуулах байгууллагыг бүртгэлээс хассан тохиолдолд өөрийгөө зохицуулах байгууллагын бүрэн эрх дуусгавар болно.

78 дугаар зүйл. Өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм, журам

78.1. Өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм, дотоод журамд дараахь зүйлийг тусгасан байна:

78.1.1. гишүүдэд тавигдах шаардлага, гишүүдийн үйл ажиллагааны журам;

78.1.2. гишүүдийн үйл ажиллагааг шалгах журам;

78.1.3. гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах тухай журам;

78.1.4. гишүүдийн мэргэжлийн ёс зүйн журам;

78.1.5. өөрийгөө зохицуулах байгууллагын бүтэц дэх хороо, салбарын үйл ажиллагааны журам;

78.1.6. үнэт цаасны зах зээлийн үйлчлүүлэгч буюу харилцагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалт;

78.1.7. гишүүдэд сургалт явуулах журам, гишүүдийн мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээний зохион байгуулалтын тухай;

78.1.8. хуурамч болон зах зээлийг урвуулан ашиглах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх болон шударга арилжааг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний зохион байгуулалтын тухай;

78.1.9. шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх ажиллагааны журам;

78.1.10. хууль тогтоомжид заасан бусад асуудал.

78.2. Өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм, дотоод журмыг уг байгууллагын удирдах зөвлөл боловсруулж Хороонд урьдчилан танилцуулж батламжлуулсны үндсэн дээр бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн батална.

78.3. Өөрийгөө зохицуулах байгууллага Хорооноос батламжлаагүй аливаа дүрэм, журамыг батлах, гишүүдээ дагаж мөрдөхийг шаардах эрхгүй. Өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм, журмыг хянах, батламжлахтай холбогдсон журмыг Хороо батална.

78.4. Тухайлан заагаагүй бол бүх гишүүдийн хурлаас баталсан дүрэм, дотоод журам нь батлагдсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болох ба тэдгээрийг хүчин төгөлдөр болсон өрдөөс эхлэн гишүүд нь заавал дагаж мөрдөнө.

79 дугаар зүйл. Өөрийгөө зохицуулах байгууллагын удирдлага, зохион байгуулалт

79.1 Өөрийгөө зохицуулах байгууллагын эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал /цаашид “гишүүдийн хурал” гэх/ байна.

79.2. Гишүүдийн хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

79.2.1. Өөрийгөө зохицуулах байгууллагын дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

79.2.2. Өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэн батлах;

79.2.3. Өөрийгөө зохицуулах байгууллагын гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, түүнд олгох хөлсний хэмжээг тогтоох;

79.2.4. Гүйцэтгэх захирлын ажлын албаны зардлын дээд хязгаарыг тогтоох;

79.2.5. Өөрийгөө зохицуулах байгууллагын удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, тэдгээрийн бүрэн эрхийн хугацааг тогтоож, гишүүний үүрэгтэй нь холбогдуулан урамшуулал олгох эсэхийг шийдвэрлэх;

79.2.6. Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, тэдгээрийн бүрэн эрхийн хугацааг тогтоож, гишүүний үүрэгтэй нь холбогдуулан урамшуулал олгох эсэхийг шийдвэрлэх;

79.2.7. Өөрийгөө зохицуулах байгууллагын жилийн төсвийг батлах, гишүүний хураамжийн хэмжээг тогтоох;

79.2.8. дүрэм, дотоод журмыг батлах.

79.3. Гишүүдийн ээлжит хурлыг жилд нэг удаа удирдах зөвлөл зарлан хуралдуулна. Гишүүдийн арваас дээш хувь нь санал гаргасан, эсхүл удирдах зөвлөлийн олонхийн саналаар шийдвэрлэсэн тохиолдолд ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

79.4. Гишүүдийн хурал нийт гишүүдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогсдын олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

79.5. Гишүүдийн хурлын хуралдааны дэгийг өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэмд заана.

79.6. Гишүүдийн хурлын чөлөөт цагт өөрийгөө зохицуулах байгууллагын эрх барих байгууллага нь есөн гишүүнээс бүрдсэн удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөлийн эрх хэмжээг өөрийгөө зохицуулах байгууллагын дүрмээр тогтооно.

79.7. Өөрийгөө зохицуулах байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг гүцэтгэх захирал удирдах ба дүрэмд өөрөөр заагаагүй бол түүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Гүйцэтгэх захирлыг нэг удаа улируулан сонгож болно.

79.8. Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг өөрийгөө зохицуулах байгууллагын дүрмээр зохицуулна.

80 дугаар зүйл. Өөрийгөө зохицуулах байгууллага болон Хороо хоорондын харилцаа

80.1. Хороо нь хууль тогтоомж, дүрэм журамд зааснаас бусад асуудлаар өөрийгөө зохицуулах байгууллагын дотоод үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

80.2. Өөрийгөө зохицуулах байгууллага нь хууль тогтоомж болон өөрийн байгууллагын дүрэм, журмыг зөрсөн гишүүдийн тухай, тэдгээрийн зөрчлийн тухай болон уг зөрчилтэй холбогдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай Хороонд шуурхай мэдэгдэх үүрэгтэй.

80.3. Хороо нь шаардлагатай гэж үзвэл өөрийгөө зохицуулах байгууллагын болон түүний гишүүдийн эрх ашигт хамааралтай аливаа асуудлаар шийдвэр гаргахаасаа өмнө өөрийгөө зохицуулах байгууллагаас болон бусад хөндлөгийн шинжээч, мэргэжилтний санал, дүгнэлтийг авч болно.

80.4. Хороо шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж зөрчсөн дүрэм, журмыг бүхэлд нь эсхүл тэдгээрийг зарим заалтыг өөрчлөх даалгавар өгөх, эсхүл хүчингүй болгох шийдвэр гаргаж болно. Хорооны шийдвэр гарсан өдрөөсөө хүчин төгөлдөр байна.

80 дугаар зүйл. Гишүүн элсүүлэх, гишүүнээс хасах

80.1. Гишүүн элсүүлэх нарийвчилсан журмыг өөрийгөө зохицуулах байгууллага дүрмээрээ тогтооно.

80.2. Гишүүнээр элсэх тухай өргөдлийг 30 хоногийн дотор хянах ба гишүүнээр элсүүлэх эсэх шийдвэрийг удирдах зөвлөл гаргана.

80.3. Удирдах зөвлөл нь дор дурдсан тохиолдолд гишүүнээс хасах шийдвэр гаргана:

80.3.1. гишүүн хүсэлт гаргасан;

80.3.2. өөрийгөө зохицуулах байгууллагын гишүүний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болсон;

80.3.3. хууль тогтоомж, дүрэм журам болон өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм, журмыг зөрчсөн.

80.4. Гишүүнээр элсүүлэхээс татгалзсан болон гишүүнээс хасах тухай шийдвэрийг хүлээн зөвөөрөхгүй бол тухайн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

81 дүгээр зүйл. Баримт бичгийг хөтлөх, шалгах

81.1. Өөрийгөө зохицуулах байгууллага нь Хорооноос тогтоосон хэлбэр, журмын дагуу гишүүдийн болон бусад шаардлагатай бүртгэлийг хөтлөн хадгална.

81.2. Өөрийгөө зохицуулах байгууллага нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа тогтоосон хугацаанд Хороонд ирүүлэх ба нийтэд мэдээлнэ.

81.3. Өөрийгөө зохицуулах байгууллага болон түүний гишүүдийн санхүүгийн байдал, баримтад шалгалт хийх хөндлөнгийн этгээдийг Хороо томилно.

81.4. Өөрийгөө зохицуулах байгууллага нь энэ хуулийн 81.3-т заасны дагуу Хорооноос томилогдсон этгээдэд шаардлагатай баримтыг гаргаж өгөх, холбогдох тайлбарыг зохих журмын дагуу шуурхай гаргаж өгөх үүрэгтэй.

82 дугаар зүйл. Өөрийгөө зохицуулах байгууллагын хариуцлага

82.1. Өөрийгөө зохицуулах байгууллага энэ хууль, өөрийн дүрэм, дотоод журмыг зөрчсөн тохиолдолд Хороо дараахь арга хэмжээ авна:

82.1.1. анхааруулга хүргүүлэх;

82.1.2. даалгавар өгөх;

82.1.3. байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийг хязгаарлах;

82.1.4. түүний бүртгэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох замаар бүрэн эрхийг дуусгавар болгох;

82.1.5. хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулах.

82.2. Өөрийгөө зохицуулах байгууллагын гүйцэтгэх захирал буюу ажилтан нь энэ хууль, байгууллагынхаа дүрэм, дотоод журмыг зөрчсөн бол Хороо түүнд анхааруулга хүргүүлэх, тодорхой ажил, албан тушаал эрхлэхийг түдгэлзүүлэх шаардлагыг тухайн байгууллагад өгч болно. Шаардлагыг хүлээн авснаас хойш асуудлыг удирдах зөвлөл, эсхүл бүх гишүүдийн хурлаараа 60 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж Хороонд мэдэгдэнэ.

82.3. Өөрийгөө зохицуулах байгууллагын бүрэн эрх дуусгавар болсонтой холбоотой түүний гишүүдийн гишүүнчлэлийг эрх бүхий өөрийгөө зохицуулах байгууллагад шилжүүлэх, холбогдох бүртгэл, тооцоог дуусгавар болгохтой холбогдсон харилцааг Хорооны журмаар зохицуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Арван хоёрдугаар дэд бүлэг

Дотоод мэдээллийг ашиглаж үнэт цаасны арилжаанд оролцох

83 дугаар зүйл. Дотоод мэдээлэл

83.1. Нийтийн хүртээл болоогүй бөгөөд тухайн мэдээлэл нь уг үнэт цаасны үнэд ноцтой нөлөө үзүүлж болох тухайн үнэт цаасыг гаргагч болон үнэт цаастай холбоотой аливаа мэдээллийг дотоод мэдээлэл гэнэ.

83.2. Нийтийн хүртээл болсон мэдээлэлд үндэслэн хийсэн дүн шинжилгээ нь үнэт цаасны ханшид мэдэгдэхүйц өөрчлөлт оруулахаар байсан ч дотоод мэдээлэл гэж тооцохгүй.

83.3. Энэ бүлэгт заасан зохицуулалт нь хөрөнгийн биржид бүртгэлгүй үнэт цаасанд хамаарахгүй.

84 дүгээр зүйл. Дотоод мэдээлэл эзэмшигч

84.1. Дор дурдсан этгээдийг дотоод мэдээлэл эзэмшигч гэнэ:

84.1.1. эзэмшиж байгаа мэдээллээ дотоод мэдээлэл гэдгийг мэдэж байгаа;

84.1.2. эзэмшиж байгаа мэдээллээ дотоод эх сурвалжаас олж авсан.

84.2. Дор дурдсан тохиолдолд мэдээллийг дотоод эх сурвалжаас авсан гэж үзнэ:

84.2.1. үнэт цаас гаргагчийн захирал, ажилтан, хувьцаа эзэмшигч болохын хувьд олж авсан;

84.2.2. албан үүргээ хэрэгжүүлэх явцад олж авсан;

84.2.3. гэрээ гүйцэтгэх явцад олж авсан.

84.3. Энэ хуулийн 84.2.1-т заасан этгээд нь мэдээллийн шууд буюу шууд бус эх сурвалж болсон эсэхээс үл хамаарч тэдгээрийг дотоод мэдээлэл эзэмшигч гэж үзнэ.

85 дугаар зүйл. Дотоод мэдээлэл ашиглахыг хориглох

85.1. Дотоод мэдээлэл эзэмшигч нь уг мэдээллийн улмаас үнэ нь хэлбэлзэх үнэт цаас болон түүний деривативын арилжаанд оролцохыг хориглоно.

85.2. Дараахь тохиолдолд дотоод мэдээллийг эзэмшигч 85.1. дэх заалтыг зөрчсөнд тооцно:

85.2.1. саналыг хүлээж авсан этгээд нь дотоод мэдээлэл гэдгийг мэдсэн эсэхээс үл хамааран ханш нь хэлбэлзэх үнэт цаас, түүний деривативын арилжаанд оролцохыг бусдад санал болгосон, ятгасан;

85.2.2. албан тушаал, ажил үүргийн хувьд мэдээллийг нээлттэй болгох үүрэг хүлээснээс бусад тохиолдолд бусдад дотоод мэдээллийг задруулсан.

85.3. Энэ хуулийн 85.1, 85.2-т заасны дагуу аливаа этгээд бүртгэлтэй үнэт цаас, түүний деривативыг арилжсан, захиалсан эсхүл тэдгээртэй холбоотой эрх олж авсан, захиран зарцуулсан, эсхүл захиран зарцуулахаар тохирсон зэрэг үйлдлийг өөрийн болон бусдын дансаар, эсхүл гуравдагч этгээдийг төлөөлөн хийсэн бол 85.1 дэх заалтыг зөрчсөнд тооцно.

85.4. Энэ зүйлд заасан зөрчил гаргасан нь гэрээ, хэлцлийг хүчингүй болгох, хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

86 дугаар зүйл. Мэдээллийг нийтийн хүртээл болгох

86.1. Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгө, санхүүгийн байдал, арилжааны идэвхи, үнэт цаасны үнэ ханшинд нөлөөлөх, бондын тухайд төлбөрийн үүргээ гүйцэтгэхэд нь саад болж болзошгүй үйл явдлын талаарх мэдээллийг нэн даруй нийтийн хүртээл болгох үүрэгтэй.

86.2. Тухайн мэдээллийг нийтийн хүртээл болгох нь үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахаар бол Хороо түүний хүсэлтээр нийтийн хүртээл болгох үүргээс чөлөөлж болно.

86.3. Энэ хуулийн 86.1-д заасан мэдээллийг нийтийн хүртээл болгохдоо Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад нэгэн зэрэг мэдэгдэнэ.

86.4. Мэдээллийг дараахь байдлаар нийтийн хүртээл болгоно:

86.4.1. арилжаа эрхлэх байгууллага болон Хорооны цахим хуудсаар;

86.4.2. Хорооноос тогтоосон журмын дагуу хэвлэн нийтлэх;

86.4.3. тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан.

Арван гуравдугаар дэд бүлэг

Зах зээлийг урвуулан ашиглах бусад хэлбэр

87 дугаар зүйл. Хуурамч арилжаа

87.1. Үнэт цаасны арилжаа идэвхитэй явагдаж байгаа мэт буюу үнэт цаасны ханшийн тухайд зах зээлийн оролцогчдыг төөрөгдүүлэхэд чиглэсэн арилжаа хийсэн бол хуурамч арилжаа хийсэнд тооцно.

87.2. Дараахь үйлдлийг арилжаа идэвхитэй явагдаж байгаа мэтээр төөрөгдүүлсэнд тооцно:

87.2.1. өмчлөгч нь өөрчлөгдөөгүй буюу холбогдох эдгээдүүдийн хооронд үнэт цаасыг худалдах, худалдан авах хэлцлийг шууд болон шууд бус замаар хийсэн, хийхэд оролцсон, хийхийг санал болгосон;

87.2.2. үгсэн хэлэлцэж ойролцоо тооны үнэт цаасыг ойролцоо үнээр худалдах, худалдан авах захиалгыг зэрэг өгөх.

87.3. Энэ зүйлд заасан “үнэт цаас” гэдэгт үнэт цаастай холбоотой фьючерсийн гэрээ, фьючерсийн гэрээний опционыг хамааруулан ойлгоно.

88 дугаар зүйл. Зах зээлийг урвуулан ашиглах

88.1. Тодорхой үнэт цаастай холбоотой хоёр ба түүнээс дээш хэлцлийг шууд эсхүл шууд бус замаар хийсэн, хийхэд оролцсон бөгөөд уг хэлцэл нь дангаараа эсхүл өөр хэлцэлтэй хавсран дараахь байдлыг бий болгож байгаа эсхүл бий болгож болзошгүй бол зах зээлийг урвуулан ашигласанд тооцно:

88.1.1. тодорхой компани, түүнтэй холбогдох компаниас гаргасан үнэт цаасыг бусад этгээд худалдан авах, захиалах, эсхүл худалдахгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ханшийг өсгөсөн, эсхүл ханш өсгөхөд чиглэсэн үйлдэл хийсэн;

88.1.2. тодорхой компани, түүнтэй холбогдох компаниас гаргасан үнэт цаасыг бусад этгээд худалдах, эсхүл худалдан авахгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ханшийг бууруулсан, эсхүл бууруулахад чиглэсэн хийсэн;

88.1.3. тодорхой компани, түүнтэй холбогдох компаниас гаргасан үнэт цаасыг бусад этгээд худалдах, худалдан авах, захиалах, эсхүл худалдахгүй, худалдан авахгүй, захиалахгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ханшийг тодорхой түвшинд барих, эсхүл тодорхой түвшинд барихад чиглэсэн үйлдэл хийсэн.

88.2. Энэ зүйлд заасан “үнэт цаас” гэдэгт үнэт цаастай холбоотой фьючерсийн гэрээ, фьючерсийн гэрээний опционыг хамааруулан ойлгоно.

89 дүгээр зүйл. Хууран мэхлэх замаар үнэт цаасны арилжаа хийлгэх

89.1. Дараахь арга замаар бусад этгээдийг үнэт цаас захиалах, худалдах, худалдан авахыг ятгасан этгээдийг хууран мэхлэх замаар үнэт цаасны арилжаа хийлгэсэнд тооцно:

89.1.1. бодит бус, төөрөгдүүлсэн, эсхүл хуурамч мэдэгдэл, амлалт, таамаг гаргах, нийтлэх;

89.1.2. чухал үйл баримтыг нуун дарагдуулах.

90 дугаар зүйл. Хууран мэхлэх зорилго бүхий арга хэрэгсэл ашиглах

90.1. Үнэт цаас захиалах, худалдан авах, худалдах талаар бусад этгээдтэй хэлцэл хийхтэй холбоотой дараахь шууд буюу шууд бус үйлдэл хийсэн этгээдийг хууран мэхлэх зорилго бүхий арга хэрэгсэл ашигласанд тооцно:

90.1.1. хэлцлийн нөгөө тал болох этгээдийг хууран мэхлэх зорилгоор ямар нэг арга хэрэгсэл ашигласан;

90.1.2. хэлцлийн нөгөө тал болох этгээдийг хууран мэхлэх, залилах зорилготой эсхүл бусдыг хууран мэхлэх, залилж болзошгүй үйлдэл хийсэн үйл ажиллагаанд оролцсон;

90.1.3. бодит үйл баримтын талаар худал мэдэгдэл хийсний улмаас хэлцлийн нөгөө тал болох этгээд төөрөгдсөн.

91 дүгээр зүйл. Хуурамч, төөрөгдүүлсэн мэдэгдэл хийх замаар үнэт цаасны хэлцэл хийлгэх

91.1. Бусдаар аль нэг компанийн үнэт цаас захиалуулах, худалдан авахуулах, худалдуулах, эсхүл тус компанийн үнэт цаасны ханшийг хэвээр байлгах, өсгөх, бууруулах, тодорхой түвшинд тогтоон барих зорилгоор уг үнэт цаасны, эсхүл тухайн компанийн үйл ажиллагаа, өнгөрсөн болон ирээдүйн гүйцэтгэлийн талаар дараахь мэдэгдэл хийсэн этгээдийг хуурамч, төөрөгдүүлсэн мэдэгдэл хийх замаар үнэт цаасны хэлцэл хийлгэсэнд тооцно:

91.1.1. тодорхой цаг хугацаа, нөхцөл байдалд чухал үйл баримтыг худал эсхүл төөрөгдүүлсэн байдлаар танилцуулсан бөгөөд өөрөө худал, төөрөгдүүлсэн гэдгийг мэдэж байсан буюу мэдэх боломжтой байсан;

91.1.2. чухал үйл баримтыг орхигдуулах замаар худал эсхүл төөрөгдүүлсэн байдал үүсгэсэн, түүнийгээ мэдэж байсан буюу мэдэх боломжтой байсан.

92 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх үүрэг

92.1. Энэ бүлэгт заасан зөрчил гаргасан нь нотлогдсон этгээд эрүүгийн хариуцлага хүлээхээс гадна тухайн зөрчлийг гаргасан этгээдийн үйлдэл буюу хэлцлийн үр дүнд өөрчлөгдсөн ханшаар үнэт цаас худалдаж авсан, худалдсаны улмаас учирсан бодит хохирлыг нэхэмжлэгчийн шаардсанаар барагдуулах үүрэгтэй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, АЛБАДЛАГА

Арван дөрөвдүгээр дэд бүлэг

Хяналт, шалгалт

93 дугаар зүйл. Мэдээлэл шаардах Хорооны бүрэн эрх

93.1. Хороо бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд, дурдсан хэлбэрээр баталгаажуулж ирүүлэхийг зохицуулалттай этгээдээс, хэрэв зохицуулалттай этгээд нь компани бол түүний хяналтын багцыг эзэмшигч, компанийн нэгдлийн бусад гишүүн компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтныг оролцуулан бусад холбогдох этгээд болон тухайн нөхцөл байдалтай холбогдол бүхий аливаа этгээдээс бичгээр шаардаж болно.

93.2. Энэ хуулийн 93.1-т заасан этгээд нь уг мэдээллийг заавал ирүүлэх үүрэгтэй.

93.3. Энэ зүйл нь бусад хуультай зөрчилдвөл энэ хуулийг дагаж мөрдөнө.

93.4. Энэ зүйлийн дагуу олж авсан байгууллага, хувь хүний нууцыг хадгалах, бусдад дамжуулахтай холбогдсон харилцааг Хороо журмаар тогтооно.

93.5 Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк нь хувьцаат компани бол тухайн банкинд энэ хуулийн 93.1, 93.2 дэх заалт нэг адил хамаарна.

93.6. Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк нь зохицуулалттай этгээдийн нэгдлийн гишүүн бол Хороо энэ хуулийн 91.1-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өмнө Монголбанкинд мэдэгдэнэ.

94 дүгээр зүйл. Байнгын хяналт

94.1. Зохицуулалттай буюу зохицуулалттай байсан этгээд нь энэ хууль, түүнд нийцүүлэн Хорооноос гаргасан дүрэм журам, тусгай зөвшөөрөл, эрхийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа буюу байсан эсэхийг тодорхойлох зорилгоор Хороо зохицуулалттай этгээдийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг тогтмол шалгаж болно.

94.2. Энэ зүйлд заасан хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 94.1-т заасан этгээд нь баримттай танилцах боломж олгож, шаардсан баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.

94.3. Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк нь хувьцаат компани бол түүнд энэ хуулийн 94.1, 94.3 дахь заалт нэг адил хамаарна.

94.4. Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк нь зохицуулалттай этгээдийн нэгдлийн гишүүн бол Хороо энэ хуулийн 94.1, 94.3-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өмнө Монголбанкинд мэдэгдэн дангаараа буюу хамтарсан хяналт шалгалт явуулна.

94.5. Монголбанкинд бүртгэгдсэн банкны зөвшөөрөлтэй банкинд Хорооны эрх бүхий этгээд 96.1.7-д заасан эрхээ хэрэгжүүлэхээс өмнө хянан шалгах ажиллагаа явуулах талаар Монгол банкинд мэдэгдэн, зөвшөөрөл авна.

95 дугаар зүйл. Зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд хийх шалгалт

95.1. Хороо энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Хорооны шийдвэрийг зохицуулалттай этгээд болон үнэт цаас гаргагч нь хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, шалгалт хийнэ.

95.2. Энэ хуулийн 95.1-д заасан хяналт шалгалтыг Хорооны даргын томилсон хянан шалгагч хэрэгжүүлнэ.

95.3. Зохицуулалттай этгээд нь энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг зөрчсөн гэж үзвэл Хороо өөрийн санаачилгаар болон иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн мэдээлэл, эсхүл гадаадын ижил төрлийн зохицуулагч байгууллагаас илүүлсэн хүсэлтийн дагуу зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд шалгалтыг хэдийд ч хийж болно.

96 дүгээр зүйл. Хянан шалгагчийн эрх хэмжээ

96.1. Хянан шалгагч нь дараахь эрх хэмжээтэй байна:

96.1.1. үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, шаардлагатай асуудлыг Хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулах;

96.1.2. хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох зохицуулалттай этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах, тэдгээрийн талаар тайлбар авах;

96.1.3. үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзсэн буюу зөрчсөн нь тогтоогдсон бол үнэт цаасны арилжааг түр зогсоох, үнэт цаасыг тусгаарлах;

96.1.4. хяналт шалгалтын дүнг үндэслэн акт тогтоох, түүний гүйцэтгэлийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг өгч шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;

96.1.5. энэ хуулийн 96.1.4-д заасан шаардлагыг биелүүлээгүй үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн зохицуулалттай этгээд болон үнэт цаас гаргагчид хуульд заасан хариуцлага хүлээлгэж, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, шаардлагатай гэж үзвэл тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгох саналыг Хороонд оруулж шийдвэрлүүлэх;

96.1.6. үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг ямар нэгэн этгээд зөрчихөөр завдаж байгааг баримтаар нотолсон, түүнчлэн зөрчлийг тогтоосон нөхцөлд төвлөрсөн хадгаламж дахь дансаар хийгдэх гүйлгээг түр зогсоох.

96.1.7. зохицуулалттай этгээдийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч байсан буюу эзэмшиж байгаа этгээдийн, эсхүл зохицуулалттай этгээдийн нэгдлийн гишүүн компаниудын байранд саадгүй нэвтрэх;

96.1.8. холбогдох баримт бичгийг хянан үзэх, түүнийг хуулбарлуулан авах;

96.1.9. шалгалттай холбоотой асуулт тавьж, хариулт авах;

96.1.10. шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

96.1.11. хууль тогтоомжид заасан бусад;

96.2. Хянан шалгагч нь Хорооны даргын баталсан удирдамжийн дагуу шалгалт хийх бөгөөд удирдамжийг зохицуулалттай этгээд болон үнэт цаас гаргагчид урьдчилан танилцуулна.

96.3. Хороо шаардлагатай гэж үзвэл шалгалтыг хийж гүйцэтгэхдээ тусгай мэргэжил, туршлага бүхий этгээдийг татан татан оролцуулж болно.

96.4. Энэ зүйлийн дагуу хийгдэж байгаа шалгалтад хамааралтай мэдээллийг агуулсан эсхүл агуулсан байж болзошгүй баримтыг эзэмшиж байгаа, эсхүл хянаж байгаа гэж улсын байцаагч үзсэн этгээд нь улсын байцаагчийн шаардсанаар баримт бичгийг шаардсан хугацаанд дурдсан хэлбэрээр гаргаж өгөх, баримтын талаар нэмэлт тайлбар, тодруулга өгөх, шаардсан хугацаанд, дурдсан газарт ирж шалгагдаж байгаа асуудалтай холбоотой тайлбар өгөх, шалгалт явуулахад боломжтой бусад хэлбэрээр туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

96.5. Шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд саад болохгүйгээр зохион байгуулна.

97 дугаар зүйл. Баримтыг устгах, гэмтээхийг хориглох

97.1. Энэ хуулийн 94, 95 дугаар зүйлд заасан хяналт шалгалттай холбоотой гэдгийг нь мэддэг буюу мэдэх ёстой этгээд уг баримтыг гэмтээх, хуурамчаар үйлдэх, нуун дарагдуулах, устгах эсхүл тийм нөхцөл бүрдүүлэх буюу зөвшөөрөх болон шалгалтаас санаатайгаар зайлсхийхийг хориглоно.

97.2. Энэ хуулийн 97.1-д заасан нөхцөл байдал тогтоогдвол Хорооноос тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

98 дугаар зүйл. Татан буулгах тухай нэхэмжлэл гаргах

98.1. Зохицуулалттай этгээдийг татан буулгах нь нийт харилцагчийн эрх ашигт нийцнэ гэж Хороо үзвэл холбогдох хуульд заасны дагуу түүнийг татан буулгах шийдвэр гаргуулах нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

98.2. Шүүх Хорооны энэ хуулийн 96.1-д заасан журмын дагуу гаргасан нэхэмжлэлийг хянаад, зохицуулалттай этгээд нь энэ хууль, тусгай зөвшөөрлийн шаардлагыг зөрчсөн болохыг тогтоовол дараахь шийдвэр гаргаж болно:

98.2.1. шийдвэрт заасан хөрөнгийг олж авах, захиран зарцуулах, бусад байдлаар ашиглахыг хязгаарлах;

98.2.2. зохицуулалттай этгээдийн хөрөнгийг эрхлэн хамгаалагч томилох;

98.2.3. хэлцлийн хүчин төгөлдөр эсэхийг тогтоох, үр дагаврыг шийдвэрлэх;

98.2.4. шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхийг зохицуулалттай этгээдэд үүрэг болгох;

98.2.5 Хорооны нэхэмжлэлд дурдсан бусад асуудал.

98.3. Шүүх нь гуравдагч этгээдэд шударга бусаар хохирол учруулахгүй гэж үзсэний үндсэн дээр энэ зүйлд заасан шийдвэр гаргана.

98.4. Шүүх энэ хуулийн 98.1-д заасны дагуу шийдвэр гаргахаасаа өмнө хүсэлт ирсэн тухай мэдэгдлийг шаардлагатай гэж үзсэн этгээдэд хүргэх, эсхүл тохиромжтой гэж үзсэн арга хэлбэрээр нийтэд мэдээлэх, эсхүл дээрх арга хэмжээг хамтад нь авч хэрэгжүүлэх даалгаврыг Хороонд өгч болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

Арван тавдугаар дэд бүлэг

Бусад зүйл

99 дүгээр зүйл. Маргаан таслах комисс

99.1. Маргаан таслах комисс нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлдэл, эс үйлдлийн талаар харилцагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд гарсан маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Хорооны орон тооны бус нэгж байна.

99.2. Хороо, Маргаан таслах комиссыг өөрийн гишүүд, ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байгуулна.

99.3. Маргаан таслах комиссын бүрэлдэхүүн, үйл ажиллагааг Хороо журмаар тогтооно.

99.4. Маргаан таслах комисс гомдлыг хүлээн авч шалгаад саналаа Хорооны хуралдаанд танилцуулна. Хороо саналыг сонсоод дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

99.4.1. саналыг хэвээр батлах;

99.4.2. саналыг өөрчлөх;

99.4.3. саналыг дахин хянаж оруулж ирэхээр Маргаан таслах комисст буцаах.

99.5. Хорооны шийдвэр эцсийн байна.

100 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

100.1. Хорооны хянан шалгагч үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

100.1.1. Тусгай зөвшөөрөлгүйгээр үнэт цаасны зах зээл дээрх зохицуулалттай үйл ажиллагаа болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж, уг этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-70 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.2. энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчиж нийтэд үнэт цаас гаргах танилцуулгад хуурамч, худал ташаа мэдээлэл тусгаж нийтэд мэдээлсэн, Хорооноос батламжилсан үнэт цаасны танилцуулгад Хорооны зөвшөөрөлгүйгээр аливаа өөрчлөлт оруулсан үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гүйцэтгэх удирдлага тус бүрийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100-150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, түүний андеррайтерийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80-120 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.3. энэ хуулийн 11.2-т заасан журмыг зөрчиж Хороогоор батламжлуулаагүй үнэт цаасыг нийтэд санал болгосон үнэт цаас гаргагчийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100-150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.4. энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан журмыг зөрчсөн хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100-150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.5. энэ хуулийн 17.2-т заасныг зөрчиж Монгол улсад бүртгэлтэй компани гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаасаа гаргахдаа Хорооноос зөвшөөрөл аваагүй бол уг хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-70 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.6. энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан нийтлэг чиг үүргээ хэрэгжүүлээгүй үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.7. энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу зохих мэдээллийг гаргаж өгөөгүй үнэт цаас гаргагч болон түүнтэй холбогдол бүхий этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.8. энэ хуулийн 24.6, 24.7, 25.3, 25.6, 30.5 дугаар зүйлд заасан журам зөрчсөн зохицуулалттай этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.9. энэ хуулийн 38-49 дүгээр зүйлд заасан зохицуулалттай үйл ажиллагааны журам зөрчсөн хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 60-80 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.10. энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг биелүүлээгүй хөрөнгийн биржийн гүйцэтгэх удирдлагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.11. энэ хуулийн 55-57 дугаар зүйлд заасан журмыг зөрчиж нягтлан бодох болон санхүүгийн тайлангаа зохих ёсоор хөтлөөгүй, холбогдох хугацаанд Хороонд ирүүлээгүй, нийтэд тайлагнаагүй зохицуулалттай этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40-60 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.12. энэ хуулийн 83-91 дүгээр зүйлд зааснаас бусад байдлаар үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчсөн, Хороо, түүний хянан шалгагчийн шаардлагыг биелүүлээгүй зохицуулалттай этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40-60 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.13. зохицуулалттай этгээд нь энэ хуулийн 37.1-д заасны дагуу Хорооноос эрх аваагүй этгээдийг мэргэжилтнээр авч ажиллуулсан бол уг зохицуулалттай этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.14. энэ хуулийн 83-91 дүгээр зүйлд заасан хориглох үйл ажиллагаа эрхэлсэн бол тухайн үйл ажиллагаанаас олсон орлогыг хурааж, зохицуулалттай этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,

100.1.15. үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар гаргасан Хорооны шийдвэрийг биелүүлээгүй зохицуулалттай этгээд, болон түүний нэгдлийн гишүүн компанийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40-60 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.16. Хорооны хяналт шалгалтад саад учруулсан иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, ажилтан, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.17. тайлан, тэнцэл мэдээ баримтыг Хороонд зохих журмын дагуу гаргаж өгөөгүй буюу энэ хуулийн 58-64 дүгээр зүйлд заасан холбогдох мэдээллийг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол тухайн зохицуулалттай этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 80-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.1.18. нийтэд хүргэсэн мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол тухайн зохицуулалттай этгээд буюу уг мэдээллийг баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтан тус бүрийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 70-100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

100.2. Зохицуулалттай этгээдийн хууль зөрчиж олсон орлогыг хурааж, зөрчлийг шалгахтай холбогдон Хорооноос гарсан зардлыг уг этгээдээр нөхөн төлүүлнэ.

100.3. Зохицуулалттай этгээд нь энэ хуулийн 100.1-д заасан торгуулыг 20 хоногийн дотор төлнө.

100.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг Иргэний хуулийн дагуу нөхөн төлүүлнэ.

100.6. Энэ хуулийн 100.1-д заасан торгуулыг үндэслэлгүй ногдуулсан гэж үзвэл захиргааны болон шүүхийн журмаар гомдол гаргаж болно.

101 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

101.1. Энэ хуулийг 2011 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ